

АГУУЛГА

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Даргын Илгээлт	2
Гүйцэтгэх Захирлын Илгээлт	4
Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх Захирлын Орлогчийн Илгээлт	5
Үйл Ажиллагаа Хариуцсан Гүйцэтгэх Захирлын Илгээлт	7
Банкны салбар 2004 онд	10
Банкны товч түүх	12
Жилийн онцлох үйл явдлууд	13
Стратеги чиглэл	14
Хамтын удирдлага	15
Байгууллагын банкны үйл ажиллагаа	16
Иргэдийн банкны үйл ажиллагаа	18
Хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаа	21
Эрсдлийн удирдлага	22
Мэдээллийн технологи	24
Хүний нөөцийн бодлого	25
Хөндлөнгийн хяналтын тайлан	27
Бүтэц зохион байгуулалт	70
Захирлуудын зөвлөлийн гишүүд	71
Салбар нэгжүүдийн хаяг	72



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Даргын Илгээлт



Н. Фабио Калиа

Хүндэт хувь нийлүүлэгчид ээ,

Юуны өмнө та бүхэнд 2004 он нь Худалдаа Хөгжлийн Банкны (ХХБ)-ны хувьд амжилт ололтоор дүүрэн жил байсныг хэлэхэд таатай байна. Тус онд манай банк олон улсын шилдэг туршлагаудыг үйл ажиллагаандаа хэвшүүлсэн, дэлхийн тэргүүлэгч банкуудад хэрэглэгддэг боловсронгуй тогтолцоо, арга барилуудыг үр дүнтэйгээр эзэмшсэн зах зээлийн үеийн банк болох зорилтоо амжилттай хэрэгжүүллээ. Өнөөдрийн байдлаар ХХБ нь Монгол улсын банкны секторын хувьд хамгийн дэвшилтэт тогтолцоо, нарийн технологитой банк болоод байна.

Эрсдлийн удирдлагын шинэлэг арга барил, тэргүүн туршлагыг нэвтрүүлсний үр дүнд банкны цаашдын өсөлтийг цогцоор удирдан, аливаа эрсдэл бүрийг зөв зүйтэй хэмжиж, хянах явдлыг баталгаажуулсан бөгөөд уг арга барилыг цаашид улам боловсронгуй болгон хөгжүүлэхээр ажиллаж байна. Жилийн хоёрдугаар хагасын туршид банкны удирдлагын баг арилжааны зээлийг нэмэгдүүлж, иргэдийн банкны үйл ажиллагааг өргөжүүлэн, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх

замаар арилжааны үйл ажиллагааг өсгөхөд голлон анхаарч ажиллав. Энэхүү хүчин чармайлтын дүнд 2004 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар банкны санхүүгийн үр дүнд үлэмж ахиц гарч, хүүгийн болон хүүгийн бус орлогыг оролцуулсан нийт орлогын хэмжээ 22.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Улмаар тус банк 2004 онд 5.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь гэнэтийн төлөвлөгдөөгүй болон дахин үнэлгээний орлого, чанаргүй зээлийн эргэн төлөлтийг эс тооцсоноор банкны түүхэн дэх хамгийн өндөр цэвэр ашигтай ажилласан жил боллоо.

Банкны тайлант онд олсон амжилтууд үүгээр хязгаарлагдахгүй бөгөөд 12 дугаар сард Азийн Хөгжлийн Банк (АХБ), Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) зэрэг дэлхийн нэр хүндтэй санхүүгийн байгууллагууд тус банкны хувь нийлүүлэгч болсон байна. Түүнчлэн эдгээр байгууллагууд 8.0 сая ам.долларыг цаашид өөрийн хөрөнгийн суурийг нэмэгдүүлэх зорилготой, захиран зарцуулах эрхтэй зээлийн хэлбэрээр олголоо. Эдгээр үйл явдлууд болон тухайн онд олсон ашгаар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн, бусад хувь нийлүүлэгчдээс нэмж хөрөнгө оруулсан зэргээс хамааран банкны өөрийн хөрөнгө тайлант оны эцсийн байдлаар 32.0 тэрбум төгрөгт хүрчээ.

Банкны 2004 оны энэ их амжилтууд нь Удирдлагын Хорооны гишүүд болох Гүйцэтгэх Захирал н.Рандолф Коппа, Банкны Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх Захирлын Орлогч н.Сийлэгмаагийн Мөнхбат, Үйл Ажиллагаа Хариуцсан Гүйцэтгэх Захирал н.Деннис Опеншоо нарын болон газар, хэлтсийн захирлууд, нийт ажилтнуудын маань хамтын хүчин зүтгэлийн үр дүн юм.

Гүйцэтгэх Захирал Р.Коппа нь 2004 онд шинээр томилогдсон бөгөөд өсөлт хөгжилтийн энэхүү шинэ үеэс тус банкныг удирдаж эхэлсэн юм. Тэрээр банкны бизнес дэх дөч гаруй жилийн туршлагаа бидэнд нийлүүлж байгаа бөгөөд түүний удирдлагын дор манай банкны үйл ажиллагаа улам бүр өсч хөгжинө гэдэгт итгэлтэй байна. Түүнчлэн би энэ завшааныг ашиглан Үйл Ажиллагаа Хариуцсан Гүйцэтгэх Захирал Д.Опеншоогийн хүчин зүтгэлийн талаар дурьдмаар байна. Д.Опеншоогийн оруулсан хувь нэмрийг ХХБ-

ны дотоодод төдийгүй, нийт банкны системийн хувьд үнэлж байгаа бөгөөд Монголбанкнаас түүнийг "2004 оны шилдэг банкир"-аар шалгаруулсан нь үүний илэрхийлэл болж байна. Р.Коппа, Д.Опеншоо нарын оруулж буй хувь нэмэр нь ХХБ-ны Голланд улсын ING банктай тогтоосон хамтын ажиллагаа, ING банкнаас тус банкинд үзүүлж байгаа удирдлагын болон техникийн туслалцааны салшгүй хэсэг юм.

Банкны Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх Захирлын Орлогч С.Мөнхбат нь Монгол улсын банкны сектор дахь хамгийн хүчтэй, чадварлаг удирдлагын багийг бүрдүүлж чадсан бөгөөд энэхүү баг нь 2004 оны туршид банкны хувьд учирсан сорилт бэрхшээлүүдийг амжилттай давж, шинэ боломжуудыг ашиглан ажилласнаар үлэмж хүчин чадлаа харуулж чадлаа. Удирдлагын багийн гишүүд, С.Мөнхбат болон газар хэлтсийн захирлуудын банкны үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр, харилцагч, хамтран ажиллагсаддаа зориулан хийж гүйцэтгэсэн ажлуудыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТҮЗ)-ийн зүгээс өндрөөр үнэлж байгаа болно. Ирэх 2005 оны туршид ч С.Мөнхбат нь банкны үйл ажиллагааны төрөл бүрийн шинэ бүтээгдэхүүнүүдийг гаргаж, шинэ зах зээлд нэвтрэн, ХХБ-ны Монгол улсын банкны секторт тэргүүлэх байр суурийг хадгалах явдлыг баталгаажуулах бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байх болно гэдэгт итгэлтэй байна.

ХХБ нь 2005 оны туршид ч өмнөх жилийн амжилтаа даваж бататгасаар байх бөгөөд хувийн банкны үйлчилгээ, хамтын зээлжүүлэлт, худалдааны санхүүжилт, төслийн санхүүжилт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг өргөжүүлэн ажилласнаар орлогыг нэмэгдүүлж, зах зээлд эзлэх байр сууриа тэлэн, Монгол улсын санхүүгийн салбарт амжилттай өрсөлдөх болно. Улмаар харилцагч зээлдэгчдийн хэрэгцээг дээд зэргээр хангаж, ирээдүйд гарч болзошгүй сорилт бэрхшээлүүдийг чадварлагаар даван туулах бат бэх суурийг бүрдүүлэх зорилгоор өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлээд байна.

Ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх үүднээс тэдгээрийг ING-гийн удирдлага, техник туслалцаа болон боломжит бусад хөтөлбөрүүдийн хүрээнд төрөл бүрийн сургалтанд хамруулах үйл ажиллагааг цаашид ч үргэлжлүүлэн явуулах болно.

Өөрийн харилцагчидтай тогтоосон хэлхээ холбоог улам бэхжүүлж, тэдний эрэлт хэрэгцээг хангахын тулд хамгийн боломжит шилдэг үйлчилгээ, бүтээгдэхүүнийг хүргэхээр ажиллах болно.

Түүнчлэн бид харилцагч банкуудтай тогтоосон харилцаагаа улам нягтруулж, ХХБ-ны банкны систем дэх хамтын ажиллагааг цаашид улам өргөжүүлэн тэлэх болно.

Монгол улсын банкны салбарын орчин тогтвортой, сайн удирдлагатай байж ирсэн нь тус салбарын хөгжилд нэн сайнаар нөлөөлсөн бөгөөд зах зээлийн тогтолцооны зарчим журмуудыг цаашид улам боловсронгуй болгож, салбарын үйл ажиллагааны тогтвортой байдал, урт удаан амжилтын эх үүсвэрийг бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх явдлыг улам баталгаажуулна гэдэгт итгэж байна.

Бид банкны үйл ажиллагааны талаар цаашид хамтран ажиллахыг бүх хувь нийлүүлэгчидээсээ хүсч байгаа бөгөөд тэдний оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг үлэмж нэмэгдүүлж, ХХБ-ны өмчлөлд оролцох эрхийг баталгаажуулсаар байх болно гэдэгт итгэлтэй байна.

2005 оны 03 дугаар сар



Гүйцэтгэх Захирлын Илгээлт



н. Рандолф Корра

ХХБ-ны 2004 оны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайланг тус банкны нэрийн өмнөөс та бүхэнд толилуулж байгаадаа нэн таатай байна.

Тус банк нь үргэлжийн хувьсал хөдөлгөөнтэй, сорилт бэрхшээлүүдээр дүүрэн бизнесийн орчны хувьд ч Монгол улсын тэргүүлэх банкны байр сууриа хадгалж, ашигтай ажилласаар иржээ. Тайлант оны хувьд татварын дараахь ашиг 5.4 тэрбум төгрөг байсан нь өмнөх 2003 оноос 108.1 хувиар өссөн үзүүлэлт боллоо.

Түүнчлэн тус онд дундаж актив 184.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 17.7 хувиар, дундаж татан төвлөрүүлсэн хөрөнгө 135.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 24.7 хувиар, жилийн эцэс дэх зээлийн өрийн үлдэгдэл 88.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 60.0 хувиар тус тус өссөн байна.

Эрсдлийн удирдлагыг улам боловсронгуй болгож, чанаргүй зээлийн хэмжээг бууруулахад онцгойлон анхаарч ажилласны дүнд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны эцсээс 5.8 тэрбум төгрөг буюу 33.0 хувиар буурсан байна.

Эргэн төлөгдсөн чанаргүй зээлийн хэмжээ нь оны туршид зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг нэмж байгуулахад зарцуулсан хөрөнгөөс давж гарсан бөгөөд жилийн эцсийн байдлаар чанаргүй зээлийн багцын 94.0 хувь нь болзошгүй алдагдлын сангаар хамгаалагдсан байна.

Тус банкны өөрийн хөрөнгийн бааз суурийг бэхжүүлснээр том харилцагчдын эрэлт хэрэгцээг хангах чадвараа дээшлүүлэх зорилт амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд тайлант оны 12 дугаар сард ОУСК болон АХБ-ны зүгээс 5 жилийн хугацаатай, 8.0 сая ам.долларын захиран зарцуулах эрхтэй зээл олгосны дээр тус бүр 1.5 сая ам.долларын хувьцааг шинээр худалдан авч, ХХБ-ны хувь нийлүүлэгч боллоо. Эдгээр үйл явдлууд болон банкны жилийн ашгаар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн зэрэг арга хэмжээний үр дүнд оны эцэс дэх өөрийн хөрөнгө нийт активийн харьцаа байвал зохих 10 хувийн үзүүлэлтийг үлэмж давуулан биелүүлж, 22.4 хувьд хүрсэн байна.

Бид олон улсын санхүүгийн нэр хүндтэй байгууллагууд манай банкны хувь нийлүүлэгч болсонд үлэмж баяртай байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын дэмжлэгтэйгээр олон улсын шилдэг туршлагауудыг эзэмшихийн тулд банкны удирдлага, засаглалыг цаашид хөгжүүлж, тэднээс хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийг амжилттай биелүүлэх замаар банкны орлого олох чадварыг улам нэмэгдүүлэхэд зорин ажиллах болно.

Санхүүгийн зуучлал үлэмж хөгжиж, банкуудын хоорондох өрсөлдөөн хэзээ хэзээнээс илүү нэмэгдсэн өнөө үед ХХБ ирэх 2005 оны хувьд ч олон олон шинэ сорилт, боломжуудтай тулгарах нь мэдээж. Энэ бүхнийг чадварлагаар угаж, амжилттай даван гарахын тулд тус банк ойрын ирээдүйд нэн тэргүүнд хэрэгжүүлэх алхмуудаа тогтоон тодорхойлоод байна. Эдгээрийн тоонд хуучин харилцагчидтай тогтоосон хэлхээ холбоогоо улам бэхжүүлэх, шинэ харилцагчид нэмж татах, хувийн банкны үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн байгууллагатай хамтарсан хамтын зээл, телефон банкны үйлчилгээ, авто машины зээл, орон сууцны зээл, шинэ төрлийн картууд зэрэг шинэ бүтээгдэхүүнүүд зах зээлд нэмж гаргах үйл ажиллагаанууд орж байгаа болно. Түүнчлэн хүү шимтгэлтэй үйлчилгээнүүдийн төрлийг нэмэгдүүлснээр тэдгээрээс орох орлогын хувийг нэмэгдүүлж, банкны бүтээгдэхүүн хүргэх сувгуудыг бүрэн ашиглаж ажиллах болно.

Ингээд би төгсгөлд нь манай банкны эрхэм хүндэт бүх харилцагчид, хамтран ажиллагсаддаа тэдгээрийн үзүүлсэн хэлбэрэлтгүй дэмжлэг, хамтын ажиллагааных нь төлөө гүн талархал илэрхийлэхийг хүсч байгаа бөгөөд энэ хамтын ажиллагаа нь ирж буй олон олон жилүүдэд ч үргэлжилсээр байх болно гэдэгт итгэж байгаагаа илэрхийлье.

2005 оны 03 дугаар сар

Банкны Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх Захирлын Орлогчийн Илгээлт



Н. Сийлэгмаагийн Мөнхбат

Өнгөрөгч 2004 он нь Монгол улсын эдийн засгийн хөгжлийн хувьд үлэмж ач холбогдолтой жил байлаа. Улсын голлох экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ дэлхийн зах зээл дээр нэмэгдэж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хувьд цаг агаар нэн тааламжтай байсан, дотоод гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн зэрэг нь Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ) 10.6 хувиар өсөхөд нөлөөлсөн бөгөөд ингэснээр Монгол улс 1991 онд зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойших хамгийн өндөр өсөлттэй жил болсон байна. Улмаар Монгол улс нь эдийн засгийн шинэчлэлийг улам гүнзгийрүүлж, өмч хувьчлалыг үргэлжлүүлснээр бизнесийн байгууллагуудын ашигт ажиллагаа нэмэгдэж байна.

ХХБ-ны хувьд өнгөрөгч он нь үйл ажиллагааны чиглэл бүрийн хувьд үлэмж амжилтанд хүрсэн жил байлаа. ING банкны мэргэжилтнүүд оролцсон шинэ удирдлагын баг банкинд хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлтийг тус онд бүрэн дуусгасан бөгөөд үүний үр дүнд үйл ажиллагааны өгөөж, чадавхи дээшилж, харилцагчдад үзүүлэх дэмжлэг нэмэгдэн, өөрийн хөрөнгө мөнгөн дүн болон нэр хүндийн хувьд өссөнөөр хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрдлээ. Улмаар энэхүү хүчин зүтгэлийн

дүнд банкны үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл бүрийн хэсгүүдэд олон улсын шилдэг туршлагаудыг хэрэгжүүлж нэвтрүүлэн, цаг үетэйгээ хөл нийлүүлж, олон улсын жишигт хүрсэн банкныг нийтийн хүртээл болгож чадсан юм.

ХХБ нь Монгол улсын санхүүгийн зах зээлд гадаад харилцааны үйл ажиллагаагаар тэргүүлэгч байр сууриа хадгалж үлдээд зогсохгүй түүнийг улам тэлж өргөжүүлсээр ирлээ. Тайлант онд тус банк Ази Номхон Далайн Зээлийн Холбооны гишүүнээр элссэн бөгөөд Украин, Казакстан, Өмнөд Солонгос зэрэг орнуудад олон улсын хамтын зээл олгоход хамтран ажиллав. Түүнчлэн бусад бүс нутгийн болон олон улсын экспорт импортын банкуудтай хамтран ажиллах болж үйл ажиллагааныхаа хүрээг улам тэлсээр байна.

Хэдийгээр өнгөрөгч он нь манай улсын хувьд эдийн засгийн үлэмж өсөлтийн жил байсан ч зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд дөнгөж 15 жилийн хугацаа өнгөрч байгаа тул эдийн засгийн хөгжлийн асуудал улс орны хамгийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байлаа. Ядуурлыг бууруулах асуудал нь Засгийн Газрын төдийгүй нийгмийн асуудал эрхэлсэн бүх байгууллагууд, улмаар ард нийтийн нэн тэргүүний асуудал болоод байна. Улс орны эдийн засгийн өсөлтөнд Жижиг Дунд Бизнес (ЖДБ)-ийн үзүүлэх үр нөлөөг дэлхийн олон орны эрдэмтэд, улс төрчид, санхүүчид хүлээн зөвшөөрсөн бөгөөд ХХБ нь энэ төрлийн бизнест үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээгээ амжилттай нэмэгдүүлж ирлээ. Өмнөх онтой харьцуулахад жижиг дунд харилцагчдын тоо 2004 онд 75.0 хувиар нэмэгдсэн бөгөөд ЖДБ-ийн зээлийн нийт багц 16.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 75.0 хувиар нэмэгдлээ.

Иргэдийн Банкны Газрын дэргэд зээл батлах тусгай зөвлөлийг байгуулж, ЖДБ-т олгох бүх зээлийг эрсдлийн нарийн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэн олгож байна.

Өнгөрөгч оноос манай банк ОУСК-тай хамтран ЖДБ эрхлэгчдэд банк санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллах, бизнесээ цаашид хөгжүүлэхэд нь тусламж зөвлөгөө өгөх зорилготой тусгай веб хуудсыг нээн ажиллуулж эхлэв. Энэхүү үйл ажиллагаа нь банкны ЖДБ эрхлэгч харилцагчдын хувьд үйл ажиллагаагаа төлөвлөх, борлуулалт, маркетингаа эрчимжүүлэхэд нь тус дэм болох алхам болсон гэж найдаж байна. Улмаар энэ нь тус банкны ЖДБ эрхлэгч харилцагчдыг цаашид улам өсч, ойрын ирээдүйд том харилцагчдын эгнээнд элсэх боломжоор хангана гэж итгэж байна.

Түүнчлэн манай банкны хувьд иргэдийн банкны нэг харилцагчид үзүүлж буй цогц үйлчилгээний хүрээг байгууллагын харилцагчдын сүлжээг ашиглан нэмэгдүүлэх боломж оршиж байна.

ХХБ нь Улаанбаатар хот болон үйлдвэрлэл, үйлчилгээний гол төв бусад хотууд болох Эрдэнэт, Дарханд бэлэн мөнгөний машинаар үйлчилж байгаа цорын ганц банк юм.

Тайлант оны туршид картын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг байнга нэмэгдүүлж байсан бөгөөд ингэснээр үйлчлүүлэгчдийн хүрээ тэлж тус банкны VISA карт эзэмшигчдийн тоо өмнөх оноос 43.0 хувиар нэмэгдсэн байна.

Цаашид бид банкны нийт орлогын хэмжээг одоогийн байгаа сүлжээ хүрээгээ улам тэлэх, нэгэнт танигдсан хүчирхэг брэндээ ашиглах замаар улам нэмэгдүүлэх болно.

Би банкныхаа нийт удирдлага, ажилтнуудад энэ их амжилтыг бүтээхийн төлөө чармайн ажилласан нөр их зүтгэлийнх нь төлөө талархал илэрхийлэхийг хүсч байна. Түүнчлэн үнэнч харилцагчиддаа байнгын дэмжлэг үзүүлж ирсэнд нь талархал илэрхийлье. Монгол улсын ард түмний амьдралыг дээшлүүлж, ХХБ-ийг улс орны тэргүүлэгч банк байлгах амлалтаа хадгалахын төлөө хүчин зүтгэх ирэх жилүүдийн туршид бид бүхэн улам хүчирхэгжин өсч, улс орноо цэцэгжүүлэн хөгжүүлэхэд хамгийн их хувь нэмрийг оруулах болно гэж итгэж байна.

2005 оны 03 дугаар сар



Үйл Ажиллагаа Хариуцсан Гүйцэтгэх Захирлын Илгээлт



н. Деннис Опеншоо

ХХБ нь 3 жилийн өмнө хувьчлагдсанаас хойш бид бүгдээр үйл ажиллагааны өөрчлөлтийн үлэмж хурдтай, өргөн цар хүрээтэй үеийг үзэж туулан, шинэ нөхцөл байдалд дасч зохицохын чухлыг суралцлаа. Үйл ажиллагааны гүн ухааны асуудлын хувьд өөрийн байгууллагын соёлыг үргэлжлүүлэн хөгжүүлж, төлөвшүүлэхээр эрэлхийлэн ажиллаж байна.

Бид 2004 онд ХХБ даяар түүний үйл ажиллагаа болон мэдээллийн технологийн системийг дахин боловсронгуй болгох үйл явцыг далайцтайгаар өрнүүлж, харилцагчиддаа зориулсан шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн, улмаар гүйцэтгэлийн чадавхи болон хувилбаруудыг хөгжүүлэх ажлуудыг эхэлсэн. Ингэж ажилласнаар бид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх арга барилаа улам боловсронгуй болгож, ХХБ-ийг түүний харилцагчид болон Монгол улсын банкны салбарын хүртээл болгож чадна гэдэгт бат итгэлтэй байна.

ХХБ-ны системийн аюулгүй найдвартай байдлыг бэхжүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь банкны салбар, улмаар нийт эдийн засагт чухал ач холбогдол бүхий асуудал болох бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах явдлыг

баталгаажуулахад үлэмж нөлөө бүхий үйл хэрэг боллоо. Энэ ажлыг хэрэгжүүлснээр бид өөрийн харилцагчид болон бусад төлбөр тооцооны байгууллагад үзүүлэх үндсэн үйлчилгээнүүдийг ямар ч тохиолдолд найдвартай явуулах нөхцлийг хангаж чадсан Монгол улсын цорын ганц банк болсон юм.

Банкны стратеги чиглэл болон нэн тэргүүнд тавигдах зорилтууд, түүний дотоод зохион байгуулалт болон хяналтын тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгосноор банкны үйл ажиллагааны дунд хугацааны шинэ төлөвлөгөөг Захирлуудын Зөвлөлөөс 2004 онд батлан гаргасан бөгөөд 2004, 2005 онуудыг хамарсан энэ төлөвлөгөөгөөр үндсэн үйл ажиллагаануудад төвлөрөх явдлыг онцгойлон анхаарч, хийж гүйцэтгэж буй ажил бүрийг төгс сайнаар хийх явдлыг урамшуулан дэмжихэд чиглэсэн гол арга замуудыг тодорхойлж өглөө.


Банкны ажилтнуудын хувьд 2004 он нь зарим нь угаас төлөвлөсөн, зарим нь хүрээлэн буй эдийн засаг, нийгэм, улс төрийн орчны хатуу ширүүн нөхцлөөс үүдэн бий болсон хэд хэдэн сорилтуудтай дахин тулгарсан жил байлаа. Гэсэн хэдий ч энэ бүгдийг амжилттай даван туулсан бөгөөд би өөрийн хувийн зүгээс банкныхаа бүх ажиллагсад жилийн туршид тэдний гаргасан нөр их хүчин зүтгэлийнх нь төлөө талархлаа илэрхийлэхийг хүсч байна. Түүнчлэн би банкны ТУЗ-ийнхэнд үзүүлж буй дэмжлэгийнх нь төлөө мөн баярласнаа илэрхийлж байна. Эдгээр бүх хүчин чармайлт, тус дэмжлэгийн үр дүнд ХХБ нь 2004 онд хувь нийлүүлэгчид болон харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, ирээдүйн сорилтуудыг давах хүчин чадвараа нэмэгдүүлж чадсан гэж үзэж байна.

Үйл ажиллагааны удирдлага нь 2005 оны туршид үргэлжлэн явагдах бөгөөд хүний нөөц, технологи, арын албаны үйл ажиллагаа, санхүү, харилцаа холбооны чиглэлээр илүү анхааран ажиллаж, зардлыг бууруулан, банкны нийт ажилтнуудыг өөрсдийн зорилгодоо хүрэхэд дэмжин ажиллах болно.

2005 оны 03 дугаар сар

Банкны уриа
Хөгжил дэвшилд хамтдаа


Эрхэм зорилго
Арилжааны болон худалдааны
Монгол Улсын шилдэг банк байх



Банкны салбар 2004 онд

Өнгөрөгч 2004 онд банкны салбарын нийт активийн хэмжээ 30.3 хувь буюу 249.9 тэрбум төгрөгөөр өсч, ДНБ-д эзлэх хувийн жин 59.5 хувь болсон байна. Энэхүү өсөлт нь нийт хадгаламж 42.5 хувь буюу 156.2 тэрбум төгрөгөөр, өөрийн хөрөнгө 51.0 хувь буюу 56.6 тэрбум төгрөгөөр, бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 69.7 хувь буюу 45.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Банкны салбарын нийт активийн 80.0 орчим хувийг том 7 банк эзэмшиж байгаа бөгөөд үлдэх 20.0 хувийг 10 жижиг банк эзэмшиж байна. Үүний дотор ХХБ нь нэг банкинд оногдох нийт активийн хамгийн их хэмжээ буюу 17.1 хувийг эзэмшиж байна.



Салбарын нийт активийн 56.8 хувийг цэвэр зээлийн өрийн үлдэгдэл, 13.7 хувийг дотоод гадаадын банкинд байршуулсан хөрөнгө, 11.1 хувийг бэлэн мөнгө болон Монголбанкинд байршуулсан хөрөнгө эзэлж байгаа нь өмнөх оны байдалтай харьцуулахад цэвэр зээлийн өрийн үлдэгдлийн нийт активт эзлэх хувийн жин 5.4 нэгжээр өсч бусад хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин ерөнхийдөө тогтвортой байна.

Сүүлийн жилүүдэд зээлийн нийт активт эзлэх хувь хэмжээ тогтмол өсч байснаас тайлант онд активийн өсөлтийн 74.7 хувийг цэвэр зээлийн өсөлт эзэлжээ. Богино хугацаатай хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын үнэт цаас нийт дүнгээрээ буурсан бөгөөд бусад төрлийн актив өсөлттэй гарчээ.

2004 онд салбарын хэмжээнд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болон бусад эх үүсвэрээс бүрдэх нийт пассивын дүн 27.0 хувь буюу 193.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 80.8 хувийг хадгаламжийн, 23.3 хувийг бусад банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт тус тус эзэлж байна.

Банкны үйл ажиллагааны байдлаас харахад 2004 онд харилцах хадгаламж хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсгийг зээлд байршуулж байгаа нь өмнөх жилүүдийн үйл ажиллагааны чиглэл хандлагатай төстэй хэдий ч зээлдэгчийг бүлэглэн авч үзэх, зээлийн нэр төрөл болон хэлбэрийг олшруулах хандлагатайгаараа онцлог шинж чанартай байна. Үүнтэй зэрэгцэн банк шинээр үйлчилгээ болон санхүүгийн бүтээгдэхүүн гаргаж байгаа нь нэг талаас уг үйл ажиллагаанаас орлого олох зорилготой байгаагаас гадна харилцагч татах, улмаар эх үүсвэрээ нэмэгдүүлэх чиглэл баримталж буйтай холбоотой байна.

Өмнөх оны байдлаас банкны нийт орлого 40.7 хувиар, нийт зардал 46.5 хувиар тус тус өсч, үүний дүнд татварын өмнөх нийт ашгийн хэмжээ өмнөх жилүүдийн байдлаас багаар буюу 14.2 хувиар нэмэгдсэн байна. 2004 онд банк салбарын хэмжээгээр 17.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Сүүлийн 2 жилийн хугацаанд банкны зарласан хүүгийн жигнэсэн дундаж болон бодит орлогоор тооцсон дундаж хүүгийн хэмжээ буурч байгаа ч эх үүсвэрт зарласан хүүгийн төвшин буурахгүй байгаа нь банк эх үүсвэр татан

төвлөрүүлж, зах зээлд тодорхой байр суурь эзлэх хандлагатай байгааг харуулж байна. Эдгээр байдлаас шалтгаалан банкны салбарын активийн өгөөжийн үзүүлэлт 2003 оны байдлаас 0.6 нэгжээр бууран 2.5 хувь боллоо.

Тайлант оны эцсийн байдлаар салбарын хэмжээгээр нийт өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн нийт активийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 20.0 хувь байгаа нь өмнөх оны байдлаас 0.4 нэгжээр буурсан бөгөөд Монголбанкнаас тогтоосон доод хэмжээнээс 10.0 нэгжээр их байна.

Банк 2004 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор дүрмийн сангаа 4.0 тэрбум төгрөгт хүргэх шаардлагатай байсан. Банк дүрмийн сангаа нэмэгдүүлэх замаар өөрийн хөрөнгөө өсгөхийн зэрэгцээ үйл ажиллагаанаас олсон ашгийн хэмжээгээр өөрийн хөрөнгө нь нэмэгдэж, 2004 онд харьцангуй их хэмжээгээр буюу 56.6 тэрбум төгрөгөөр өсчээ. Гэвч банк татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд харьцангуй их эрсдэлтэйгээр тооцогддог активт буюу зээл болон бусад гадаад дотоодын банкинд байршуулах хандлагатай байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оны байдалтай харьцуулахад бага өөрчлөлттэй байх гол шалтгаан болж байна.



Банкны товч түүх

ХХБ нь дэлхий даяар өөрчлөлт шинэчлэлтийн шинэ давалгаа өрнөж, жилдээ улс орны ДНБ-ний гуравны нэгтэй тэнцэхүйц хэмжээний тусламж дэмжлэг үзүүлдэг байсан хөрш Зөвлөлт Холбоот Улс задран унасан 1990 онд үйл ажиллагаагаа эхэлсэн. Байгуулагдсан цагаас эхлэн Монгол улсыг нийтэд нь хамарсан улс төрийн болон байгалийн хүчин зүйлүүдээс үүдэлтэй эдийн засгийн гүн гүнзгий хямрал, зах зээлийн чөлөөт тогтолцоонд шилжиж, төрийн өмчийг өргөн далайцтайгаар хувьчилсан эдийн засгийн шинэчлэлийн үр дүнд бий болсон эдийн засгийн өсөлт зэргийн аль алиныг үзэж туулсан ч зах зээлийн болон харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг амжилттай хангасан улс орны тэргүүлэгч банкны байр сууриа тогтвортой хадгалсаар ирлээ.

Эдийн засгийн шинэчлэлийн нэг хэсэг болох банкны салбарын бүтцийн өөрчлөлт ч өнгөрсөн хугацааны туршид эрчимтэй явагдсан бөгөөд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд нарийн тодорхой болж, банкны үйл ажиллагааны зөвшөөрөл олгох болон зогсоох хууль журмууд боловсронгуй болон, зээлийн эргэн төлөлт нэн тэргүүнд анхаарах асуудал болсон байна. Улмаар Засгийн Газрын зүгээс санхүүгийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги, урт хугацааны хэтийн төлвийг боловсруулан гаргалаа.

Эдгээр арга хэмжээний дүнд ард олны банкны салбарт итгэх итгэл сэргэж, харилцах данс болон хадгаламжийн хэлбэрээр орж ирэх хөрөнгө нэмэгдэн, зээл олголт үлэмж өссөн байна. Зээл болон зээлийн барьцааны талаархи хууль журмуудыг улам боловсронгуй болгосноор банкны салбарын зээлжүүлэх чадавхи үлэмж нэмэгджээ.

Улмаар 2001 оны 12 дугаар сард Монгол улсын Засгийн Газрын ХХБ-нд эзэмшиж байсан 76.0 хувийн өмчлөх эрхийг Globull Investment and Development Inc. (SCA) буюу Швейцар улсын Banca Commerciale Lugano, АНУ-ын Gerald Metals Inc нарын хамтарсан консорциум худалдан авснаар Монгол улсын хамгийн том арилжааны банк хувьчлагдсан байна.

ХХБ-нд 2003 оноос Голланд улсын дэлхийд алдартай ING банкны удирдлага, техникийн туслалцаа хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү үйл явдал нь ХХБ-ийг Монгол улсын банкны салбар дахь тэргүүлэгч байр сууриа хадгалан ажиллахад төдийгүй, олон улсын зах зээлд үйл ажиллагаагаа тэлэхэд нь нэн чухал алхам болсон юм.

Банк өөрийн эх үүсвэр хөрөнгөө хэрхэн зээлжүүлж байгаа нь зөвхөн өөрийн нь үйл ажиллагааны хэмжүүр болоод зогсохгүй улс орны эдийн засаг, банкны харилцагч-үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл бүрийн бизнес эрхлэгчдийн цаашид өсч хөгжин дэвжихэд үлэмж нөлөөтэй байдаг. Үүний улмаас ч ХХБ нь өөрсдийн харилцагчдын хамт хөгжил дэвшилд хамтдаа урагшлахыг эрхэм зорилгоо болгосон болно.

Өнгөрсөн үеийн ололт амжилтууд

- 2001 Монгол Улсын Тэргүүлэгч Банк (The Banker сэтгүүлийн шалгаруулалтаар)
- 2001 Шинэ Зах Зээл Хөгжүүлэгчийн шагнал (VISA International-ийн шалгаруулалтаар)
- 2002 Монгол Улсын Тэргүүлэгч Банк (The Banker сэтгүүлийн шалгаруулалтаар)
- 2003 Маркетингийн Үйл Ажиллагааг Гарамгай Хэрэгжүүлэгчийн шагнал (VISA International-ийн шалгаруулалтаар)



Жилийн онцлох үйл явдлууд

- 1 Олон улсын нэр хүндтэй санхүүгийн байгууллагууд болох АХБ болон ОУСК-аас банкны өөрийн хөрөнгөд хувь нийлүүлснээр өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн нийт активийн харьцааны үзүүлэлт 49.0 хувиар өсч, 22.4 хувь болсон.
- 2 Гадаад орны хямд эх үүсвэрийг татаж, импортыг дэмжих зорилгоор Тайван, Солонгос улсуудын Exim банкны зээлийг олгож эхэлсэн.
- 3 ING, Deutsche bank, Citigroup, RZB зэрэг дэлхийн томоохон банкуудтай хамтран Өмнөд Солонгос, Украин, Казахстан улсын зээлдэгчдэд хамтын санхүүжилтийн зээл (syndicated loan) олгож эхэлсэн нь Монгол улсын банкны салбарт энэ чиглэлээр гаргасан анхны бөгөөд цоо шинэ бүтээгдэхүүн болсон.
- 4 Монгол улсын арилжааны банкуудаас хамгийн анхлан гадаадад алт экспортлох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.
- 5 Банкны үндсэн бүртгэл тооцоог хөтлөх BANCS программыг шинэчлэх нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлсэн.
- 6 Хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотод орших нийт 17 салбар нэгжийг төв банктай онлайн холболттой болгосон.
- 7 Удирдлагын мэдээлийн болон эрсдлийн удирдлагын системийг шинэчилж, нэвтрүүлсэн.
- 8 Чинээлэг харилцагчиддаа зориулж хувийн банкны үйлчилгээг нэвтрүүлсэн.
- 9 Зах зээл дэх байр сууриа улам бэхжүүлэхээр Инвеском ББСБ-ыг нэгтгэн авсан нь банк ББСБ-тай нэгдсэн Монгол улс дахь анхны үйл явдал боллоо.
- 10 Тус банкны Үйл Ажиллагаа Хариуцсан Гүйцэтгэх Захирал н.Д.Опеншоо Монголбанкны шалгаруулалтаар "2004 оны шилдэг банкир"-аар шалгарсан.
- 11 Үйл Ажиллагаа Хариуцсан Гүйцэтгэх Захирал н.Д.Опеншоог Гадаадын Хөрөнгө Оруулалт Гадаад Худалдааны Агентлагаас "2004 оны хөрөнгө оруулалтын элч"-ээр шалгаруулсан.



- 12 Арилжааны, үйл ажиллагааны болон мэдээллийн технологийн чиглэлийн үйл ажиллагааг олон улсын шилдэг жишигт нийцүүлэн өөрчилж боловсронгуй болгосон.
- 13 Бодлого, журмууд, тогтолцоо болон үнэлэлт дүгнэлт өгөх үйл явцуудыг харилцан уялдаа холбоотой, нэгдмэл болгосон.
- 14 Олон улсын төлбөр тооцооны SWIFT системийг өргөтгөж SWIFT NET системд амжилттай оруулсан.
- 15 Телефон банкны үйлчилгээ, харилцагчдын төлбөрийн даалгаврыг факсаар хүлээн авах зэрэг шинэ бүтээгдэхүүнүүд гаргасан.
- 16 Банкны веб хуудсыг шинэчилж гаргасан.



Банкны стратеги чиглэл

2004 оны стратегийн зорилтууд

- Банк санхүүгийн зах зээлд эзлэх тэргүүлэгч байр сууриа улам бэхжүүлэх
- Зорилтот харилцагчид, тэдний бизнесийг хөгжүүлэхэд төвлөрч ажиллан, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн төрөл бүрийн, орчин үеийн дэвшилтэт, шинэ бүтээгдэхүүнүүдээр чанартай үйлчлэх
- Том харилцагчдын эргэлтийн хөрөнгө болон худалдааны санхүүжилтийн хэрэгцээг бүрэн хангахын тулд өөрийн хөрөнгө, татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө хэмжээг нэмэгдүүлэх
- Дотоод үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх
- Улмаар харилцагчдад хамгийн сайн хүрч чадсан тэргүүний шилдэг үйлчилгээг эелдэг боловсон ажилтнууд, орчин үеийн техник тоног төхөөрөмжүүдээрээ дамжуулан хүргэснээр банкны үйлчилгээний өөрийн гэсэн хүчирхэг брэндийг зах зээл дээр хамгаалж ажиллах



Хамтын удирдлага

Тус банкны хувьд 2004 он нь хамтын удирдлагын зарчмуудыг амжилттай хэрэгжүүлэн хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг нэмэгдүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлтэй, шударга, хариуцлагатай байдлыг хангах талаар шинэ шинэ үйл явдлууд өрнөсөн онцлог жил байлаа.

Бүтэц зохион байгуулалтыг 2003 оны 8 дугаар сард олон улсын банкны үйл ажиллагааны жишигт нийцүүлэн өөрчилж, газар хэлтэс нэгжүүдийг тэргүүн эгнээний буюу харилцагчдад үйлчлэх хэсэг, үйл ажиллагааг дэмжих болон арын албаны хэсгүүдэд хуваан шинэчлэн зохион байгуулсны дагуу тэдгээрийн үүрэг зорилт, улмаар нийт банкны стратеги чиглэлийг тусгасан дунд хугацааны төлөвлөгөөг ТУЗ-өөс батлан гаргаж, мөрдөж ажиллалаа.

Түүнчлэн хамтын удирдлагын тогтолцоог улам боловсронгуй болгох үүднээс Банкны дүрэм, дотоод журам, холбогдох заавруудыг шинэ бүтэц зохион байгуулалтыг тусган шинэчлэн боловсруулав.


Хамтын удирдлагын гол зорилтуудын нэг болох хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг өсгөх ажлыг 2004 онд амжилттай хэрэгжүүлж, 5.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллан, өөрийн хөрөнгийг мөн хэмжээгээр нэмэгдүүлсэн байна.

Улмаар хувь нийлүүлэгчдэд ил тод, нээлттэй байх зарчмыг байнга сахиж ажиллалаа.

Тус банкны хувьд 2004 онд болсон чухал үйл явдлуудын нэг нь шинээр хувьцаа гаргаж, хувь нийлүүлэгчдийн бүтцэд нэлээд өөрчлөлт гарсан явдал юм. Банкны 2004 онд гаргасан нийт хувьцааны 73.2 хувийг олон улсын нэр хүндтэй санхүүгийн байгууллагууд болох АХБ болон ОУСК худалдан авсан бөгөөд ингэснээр эдгээр байгууллагууд Globull Investment and Development Inc. (SCA)-гийн дараахь хамгийн том хувь нийлүүлэгчид болсон байна. ОУСК-ийн үндсэн үйл ажиллагаануудын нэг нь Дэлхийн Банкнаас хөгжиж буй улс орнуудын хувийн секторт хөрөнгө оруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал бөгөөд АХБ-тай хамтран ХХБ-д хувь нийлүүлсний дээр 9.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй зээлийн хэлбэрээр нийлүүлсэн нь тус байгууллагаас Монгол улсын банкны секторт хөрөнгө оруулсан анхны үйл явдал болсон байна.



АХБ, ОУСК-аас хийсэн хөрөнгө оруулалт нь олон улсын нэр хүндтэй байгууллага Монгол улсын банк болон түүний харилцагчдад итгэл, дэмжлэг үзүүлж, тэдний нэр хүндийг олон улсын тавцанд өргөсөн, манай улсад орох гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулахад түлхэц өгсөн, улмаар ХХБ хамтын удирдлагын шилдэг зарчмуудыг олон улсын байгууллагуудын оролцоотойгоор улам амжилттай хэрэгжүүлж, банкны үйл ажиллагааны эрүүл, найдвартай байдлыг тогтвортой хангаж ажиллахад үлэмж нөлөө үзүүлсэн чухал үйл явдал боллоо.



Байгууллагын Банкны үйл ажиллагаа


Байгууллагын Банкны Газар (ББГ)-ын 2004 оны гол зорилт нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээг стратегийн ач холбогдол, нөлөө бүхий харилцагчдад хүргэж борлуулах, тэдгээрт зээл, гадаад худалдааны санхүүжилт, төслийн санхүүжилт зэрэг үйлчилгээг цогцоор үзүүлэх замаар шинэ харилцагчдыг нэмж татах явдал байлаа.

2004 оны эдгээр зорилтууд амжилттай биелсэн бөгөөд байгууллагын банкны үйлчилгээг хүлээн авагч хуучин болон шинээр нэмж татсан харилцагчиддаа зориулж нийт 153.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Олгосон зээлийг салбарын ангиллуудаар авч үзвэл үйлдвэрлэлийн салбарт 22.0 хувь, уул уурхайн салбарт 19.0 хувь, мах боловсруулах салбарт 16.0 хувь, нефть импортлогчдод 13.0 хувь, барилгын салбарт 8.0 хувь, худалдааны салбарт 6.0 хувь, аялал жуулчлалын салбарт 1.0 хувь, үлдсэн 15.0 хувийг бусад салбарт олгожээ.

Нийт зээлийн 60.0 орчим хувийг бизнесийн зээл, 16.0 хувийг зээлийн шугамын эрх, 14.0 хувийг төслийн зээл, 11.0 хувийг хамтын санхүүжилттэй зээлүүд эзэлж байна.



Тус газраас олгосон зээл 2003 оны эцэстэй харьцуулахад 2004 онд 60.0 хувиар нэмэгдсэн бөгөөд энэ нь ХХБ-ны дэмжсэн харилцагчдын үйл ажиллагаа өсч хөгжин зээлийн хэрэгцээ шаардлага нь нэмэгдсэн, Монгол улсын эдийн засаг 10.0 хувиар өссөн, тус газар өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг зөвхөн хүсэлт гаргаж хандсан харилцагчдад хүргэх бус маркетинг сурталчилгааны ажлыг идэвхтэй явуулах замаар шинэ харилцагчид татах бодлого баримталсан, банкны өөрийн хөрөнгө нэмэгдсэний улмаас нэг зээлдэгчдэд олгох зээлийн дээд хязгаар нэмэгдсэн, харилцагчдын өсөн нэмэгдсэн эрэлт хэрэгцээнд зориулан стратегийн ач холбогдол бүхий шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлсэн зэрэгтэй холбоотой байлаа.



Өөрийн уламжлалт бүтээгдэхүүнүүд болох эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэнд зориулан олгодог урт богино хугацаатай бизнесийн зээл, Дэлхийн банк, Германы KFW банкны төслийн санхүүжилтийн зээлээс гадна гаднын хямд эх үүсвэрийг татаж импортыг дэмжих зорилгоор Тайван, Солонгос улсуудын Exim банкны зээлийг олгож эхэлсэн.

Түүнчлэн ING, Deutsche bank, Citigroup, RZB зэрэг дэлхийн томоохон банкуудтай хамтран Өмнөд Солонгос, Украин, Казахстан улсын зээлдэгчдэд хамтын санхүүжилтийн зээл олгож эхэлсэн нь Монгол улсын банкны салбарт энэ чиглэлээр гаргасан анхны бөгөөд цоо шинэ бүтээгдэхүүн болсон юм. Улмаар энэ нь банкны харилцаа холбоог тэлж, эрсдлийг тархаасан, хөрш зэргэлдээ орнуудын зах зээлд нэвтрэхэд түлхэц болсон чухал үйл явдал болсон байна.

Банкны дотоодод хугацаа хэтэрсэн зээл болон хүндрэлд орж болзошгүй зээлдэгчидтэй ажиллах тусгай хэсгийг байгуулан ажилласнаар зээлийн багцын чанар үлэмж сайжирч, чанаргүй зээлийн хэмжээ 18.5 хувиар буурлаа.



Иргэдийн банкны үйл ажиллагаа

Иргэдийн Банкны Газар (ИБГ)-ын зорилго нь өөрийн харилцагчид болох амжилттай хөгжиж байгаа ЖДБ эрхлэгчид, ББГ-ын харилцагч аж ахуйн нэгжүүдийн эзэмшигч, албан тушаалтан, ажилтнууд болох хувь хүмүүс болон бусад иргэдэд орчин үеийн банкны төрөл бүрийн дэвшилтэт бүтээгдэхүүнүүдийг өөрийн онцлогтой, найдвартай, шуурхай, чанартай үйлчилгээгээр хүргэх явдал юм.

Уг зорилтыг хэрэгжүүлэх үүднээс тус газрын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, чанар, үйлчилгээ үзүүлэх чадавхи, улмаар ашиг орлогын хэмжээ 2004 онд байнга нэмэгдэж ирлээ.



Зээл, хадгаламжийн үйлчилгээ

ИБГ 2004 онд банкнаас олгосон нийт зээлийн 21.5 хувь болох 42.0 тэрбум төгрөгийн зээлийг 3 төрлийн бүтээгдэхүүнээр дамжуулан олгосон бөгөөд зээлийн хүүний орлого 3.5 тэрбум төгрөг байсан нь нийт банкны хүүний орлогын 22.4 хувьтай тэнцэж байна.

Тус газрын ашигт ажиллагаа нэмэгдэж, харилцагчдын үйл ажиллагаа өсөхийн хирээр жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид болон хувиараа бизнес эрхлэгч иргэдийн бизнесийн хэрэгцээнд зориулан олгох зээлийн дээд хэмжээг 50.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 100.0 сая хүртэлх төгрөгийг олгодог болсны дээр 7 дугаар сараас зээлийн хүүгийн хувь хэмжээг буурууллаа. Жижиг зээлийг төгрөгөөс гадна ам.доллараар олгож эхлэв.



Хадгаламжийн үйлчилгээний хувьд нөхцөлт мөнгөн хадгаламж, урьдчилсан хүүт хадгаламж, хувийн банкны төвийн гэрээт хадгаламж, тусгай нөхцөлт мөнгөн хадгаламж зэрэг шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэдийн хадгаламж оны эцэст 39.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Төлбөр тооцооны үйлчилгээ

MoneyGram-ын үйл ажиллагаа эрхэлдэг ХХБ болон Инвэсском ББСБ 2004 онд нэгдсэнээр ХХБ нь тус оны 8 дугаар сард Монгол улс дахь MoneyGram-ын албан ёсны ганц төлөөлөгч байгууллагын эрхийг хүлээж авсан. Улмаар Монгол улсын санхүүгийн зах зээлд MoneyGram-ын үйл ажиллагаа явуулдаг өөрийн төлөөлөгч банкууд болох Монгол Шуудан, Капитрон, ХАС, Анод, Хадгаламж, Интер, Эрэл, Капитал, Улаанбаатар хотын банкуудтай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, сүлжээний нэгтгэл хийлээ.

Өөрийн харилцагчдад үйлчилгээг хүргэх арга замуудыг хөнгөн шуурхай, боловсронгуй, зардал багатай болгож автоматжуулах, улмаар банктай харилцах хамгийн хялбар тохиромжтой арга замуудаа сонгож үйлчлүүлэх боломжуудыг нь бүрдүүлэн хангахын тулд 7 хоногийн 24 цагийн турш банкны үйлчилгээний талаар мэдээлэл өгөх төв (Call Center)-ийг байгуулж, банкны цахим хаягт хандаж дансны хуулга, бусад хэрэгцээтэй мэдээллийг авах, үлдэгдлээ хянах болон гар утсаараа дамжуулан дансны үлдэгдлээ шалгах (SMS Banking), иргэдийн харилцах дансанд факсаар баримт хүлээн авч төлбөр тооцоог гүйцэтгэх үйлчилгээнүүдийг тус тус нэвтрүүлэв. Мөн 2004 оноос эхлэн салбар банк, тооцооны төвүүд өөрийн харилцагчдад Эскроу дансны үйлчилгээ үзүүлж эхлээд байна.



American Express замын чекүүдийн алдагдсан, хаяж үрэгдүүлсэн эсэхийг онлайн сүлжээгээр шууд шалгах үйлчилгээг шинээр судлан хэрэгжүүлж, Монголд анх удаа уг үйлчилгээг нэвтрүүлэн ажиллах эрхийг хүлээн авлаа.



Картын үйлчилгээ

ИБГ-аас харилцагчиддаа үзүүлэх үйлчилгээний нэг гол хэсэг нь бэлэн бус төлбөр тооцооны картын бүтээгдэхүүн үйлчилгээ бөгөөд энэ чиглэлээр Монгол улсын зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалсан хэвээр байна.

Тус банк 2004 онд өөрийн харилцагчиддаа Монгол улсад хэрэглэгдэх энгийн, залуучуудын, цалингийн VISA картууд, олон улсад хэрэглэгдэх энгийн, алтан, байгууллагын дебит, байгууллагын кредит VISA, байгууллагын American Express зэрэг нэр төрлийн картуудыг санал болгож үйлчиллээ.


2004 оны байдлаар VISA картаар үйлчлүүлэгч байгууллагын тоо 450, цалингийн гэрээт байгууллага 180 орчим болж нийт карт эзэмшигчийн тоо 27 000 гаруй байна. Улмаар VISA International байгууллагын төлөөлөгчид "Монголын банкуудын гаргаж буй төлбөрийн картуудын дундаас ХХБ-ны төлбөрийн картууд нь хамгийн идэвхтэй хэрэглээтэй байгаа болно" гэж мэдэгдэж байгаа билээ.

ХХБ нь VISA картын үйлчилгээнээс гадна AMERICAN EXPRESS, MASTERCARD, JCB гээд дэлхийд тэргүүлэгч

картуудаар төлбөр хүлээн авах боломжийг өөрийн харилцагчиддаа олгодог цорын ганц банк хэвээр байна.

ХХБ нь Visa картын үйлчилгээний нэг хэсэг болох бэлэн мөнгөний машиныг Монгол улсад анх удаа нэвтрүүлсэн банк бөгөөд одоо ч энэ үйлчилгээг зөвхөн тус банк үзүүлсэн хэвээр байна. 2004 онд 24 цагийн турш байнгын ажиллагаатай бэлэн мөнгөний машин Улаанбаатарт 17, хөдөө орон нутагт 3 байсан ба эдгээрээр дамжуулан бэлэн мөнгө олгох, дансны үлдэгдлээ шалгах, гүйлгээний товч хуулга өгөх үйлчилгээнээс гадна Мобиком, MCS, MICOM компаниудын олон улсын ярианы болон гар утасны нэгжийн урьдчилсан төлбөрт картуудыг худалдах зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлж байна.

Картын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулахад 2004 онд байнга анхаарч ажилласан ба бүх төрлийн дебит картанд орлогын түвшинтэй уялдуулж 30 хоногийн дотор эргэж төлөгдөх нөхцөлтэй зээлийн эрх олгох, 5 сарын цалинтай тэнцэх хэмжээний цалингийн зээлийг 10 хүртэл сарын хугацаатай олгох зэрэг үйлчилгээг үзүүлж байна.



Хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаа

ХХБ-ны хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаа нь банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, заавал байлгах нөөцийн удирдлага болон зах зээлийн эрсдлийн удирдлагын зэрэгцээ ашиг олох зорилгоор алт, гадаад валют, үнэт цаасны арилжаа хийх, мөнгөний зах зээлийн үйл ажиллагаа явуулах, актив пассивийн удирдлагыг хэрэгжүүлэх ажиллагаанаас бүрдэнэ.

Алтны арилжаа

ХХБ нь Монгол улсын банкны салбарт анх удаа алтны арилжаа эрхлэх зөвшөөрөл 2000 онд авснаас хойш дотоодын алтны зах зээл дээр тэргүүлэх байр сууриа хадгалж ирлээ. Улмаар өнгөрөгч 2004 онд Монгол улсын арилжааны банкуудаас хамгийн анхлан гадаадад алт экспортлох үйл ажиллагааг хэрэгжүүлснээр алтны арилжаанаас олох ашиг орлогын хэмжээг үлэмж нэмэгдүүлэх боломжтой болов. Түүнчлэн дотоодын зах зээл дээр алт олборлогч харилцагчидтай нягт хамтран ажиллаж, тэдгээрийг ханшийн эрсдлээс хамгаалах зорилгоор алтны опшин арилжааг нэвтрүүлсэн нь шинэлэг үйл ажиллагаа болсон юм. Эдгээрийн дүнд гадаадын зах зээл дээрх үйл ажиллагаагаа өргөжүүлж чадсан нь ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулж, алтны арилжаанаас нийтдээ 591.0 сая төгрөгийн ашиг оллоо.

Гадаад валютын арилжаа

ХХБ нь Монгол улсын банкны салбарын хувьд хамгийн их гадаад актив эзэмшигч бөгөөд энэ нь гадаад валютын хамгийн том арилжаа эрхлэгч байх боломжийг бүрдүүлдэг. Хэдийгээр 2004 онд гадаад дотоодын валютын зах зээл хэлбэлзэл ихтэй байсан ч тус банкнаас хэрэгжүүлсэн оновчтой үйл ажиллагааны дүнд валютын арилжаанаас олох ашгийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, 2.1 тэрбум төгрөгт хүргэлээ. Дотоодын валютын зах зээл дээр хөрвөх чадварыг хангаж, эргэлтийг хурдасгах тал дээр анхаарч ажилласан нь харилцагчдын тоо хэмжээг нэмэгдүүлээд зогсохгүй энэхүү бизнесээс олох ашгийн хэмжээг өсгөхөд нөлөөлөв. Улмаар олон улсын валютын зах зээл дээрх ашиг олох зорилготой арилжаанаас олох ашгийн хэмжээ нэмэгдсэн нь нийт ашиг нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

Үнэт цаасны арилжаа

Монголбанк болон Засгийн Газрын үнэт цаасны арилжаанд тогтмол оролцож эдгээр үнэт цааснуудын зах зээл дээрх өөрийн голлох байр суурийг хадгалан ажиллав. Мөнгөн хөрөнгө, хөрвөх чадварын удирдлагын үр ашигтай байдлыг хангах үүднээс үнэт цаасны хоёрдогч зах зээлд идэвхтэй оролцож, хамгийн

том оролцогч нь байсан төдийгүй нийтдээ 235.0 тэрбум төгрөгийн арилжаа хийж, үнэт цаасны хүүгийн орлого 1.56 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Актив пассивийн удирдлага

Актив пассивийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, хүүгийн эрсдлийг бууруулах талаар анхаарч ажилласны дүнд тодорхой хэмжээний дэвшлүүд гарсан. Тухайлбал багцын удирдлагыг боловсронгуй болгохтой холбоотойгоор олон улсын мөнгөний зах зээлд нэвтэрч, богино хугацааны үнэт цаасны арилжаанд оролцож эхэлсэн ба энэ үйл ажиллагаанаас нийтдээ 51.9 сая төгрөгийн хүүгийн орлого оллоо. Түүнчлэн тэнцлийн зохистой бүтцийг бий болгож, бүтээгдэхүүний үнэлгээг гадаад, дотоодын зах зээлийн өөрчлөлтүүдтэй уялдуулан цаг тухайд нь оновчтой хийж байсан нь цэвэр хүүгийн орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Хөрөнгө зохицуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх хэд хэдэн аргуудыг туршсаны эцэст ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, салбар нэгжүүдийн үйл ажиллагааг үнэлэх зорилго бүхий дотоод хүүгийн аргыг бүрэн нэвтрүүлж хэрэгжүүлж байна.



Эрсдлийн удирдлага

Банкны үйл ажиллагааг амжилттай явуулах нь зөвхөн зээл олгож, бүтээгдэхүүнээ их хэмжээгээр борлуулж байгаагаас бус харин тэдгээрийн эргэн төлөгдөх эрсдлийг хэрхэн бууруулж байгаагаас үлэмж хамааралтай бөгөөд улмаар банкны бизнесийн гол мөн чанар нь эрсдлийг зүй зохистой удирдах явдал юм.

ХХБ өөрийн үйл ажиллагаанаас үүдэн бий болох төрөл бүрийн эрсдлийг зөв тодорхойлох, тэдгээрийг нэгдсэн хэлбэрээр олон улсын түвшинд хүрсэн арга барилаар удирдах, хянах зорилгоор бие даасан статустай Эрсдлийн Удирдлагын Газар (ЭУГ)-ыг 2003 оны 4 дүгээр улирлаас байгуулан ажиллаж эхэлсэн бөгөөд өнгөрөгч 2004 он нь тус банкны хувьд эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг бодит утгаар нь хэрэгжүүлсэн анхны жил байлаа.

ЭУГ нь дотоодын банк, санхүүгийн зах зээлийн өвөрмөц онцлог, тус банкны үйл ажиллагааны шинж чанартай холбогдуулан эрсдлийг зээлийн, хүүгийн, төлбөрийн чадварын болон зах зээлийн гэсэн хэлбэрүүдэд ангилан үзэж, олон улсын түвшинд хүрсэн эрсдлийг хэмжих, удирдах арга барилыг хэлбэр тус бүрт нь тохируулан ашиглах замаар удирдаж байна.


Зээлийн эрсдэл

ХХБ зээлийн эрсдлийн удирдлагыг нэг зээлдэгч, нэг бүлэг зээлдэгч, улмаар бизнесийн салбар тус бүр дээр банкны үүрч болох эрсдлийн хэмжээ хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд хяналт тавих замаар хэрэгжүүлж байна.

Өнгөрсөн 2004 онд зээлийн эрсдлийн удирдлагыг сайжруулах үүднээс хэд хэдэн чухал арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Зээлийн шийдвэр гаргах үйл ажиллагаа эрсдлийг бууруулахад чиглэгдэж өөрчлөгдсөн.
- Зээлийн эрсдлийг удирдах нэгдмэл тогтолцоотой болсон.
- Олгосон зээлд тавигдах хяналтыг сайжруулсан.
- Чанаргүй зээлийн эргэн төлөлтийг сайжруулах үүднээс Зээлийн Бүтцийн Өөрчлөлтийн Албыг шинэчлэн зохион байгуулсан.

Зээлийн шийдвэр гаргах схем



Зээлийн эрсдлийн удирдлагыг зөвхөн шинээр зээл олгох үйл ажиллагаанд бус олгосон зээлийг эргэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд хянах замаар хэрэгжүүлж байна. Ийнхүү зээлийн эрсдлийн удирдлагыг сайжруулан, шинэ тогтолцоонд шилжиж ажилласны дүнд 2004 онд тус банкны зээлийн үйл ажиллагаанд зарчимын ахиц гарч, зээлийн багцын чанар нэлээд сайжирлаа.



Тухайлбал өнгөрсөн 2004 оны эцсийн байдлаар нийт чанаргүй зээлийн хэмжээ оны эхэнтэй харьцуулбал 23.7 хувиар буурсан ба үүний дүнд чанаргүй зээлийн нийт багцад эзлэх хэмжээ 80.0 гаруй хувиар буурсан байна.

Зах зээлийн эрсдэл

ХХБ энэхүү эрсдлийг удирдахад "Хамгийн их эрсдлийн арга" буюу VaR аргыг ашигладаг бөгөөд уг аргаар хэмжин гаргасан эрсдлийн хэмжээ нь батлагдсан VaR лимитын хүрээнд байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг.

Тайлант оны бодит VaR утгууд

Тайлант он	Хамгийн их VaR утга	Хамгийн бага VaR утга	Дундаж VaR утга
2004 он	143.3 сая.төг	5.9 сая.төг	31.6 сая.төг

Тайлбар: Тус банкны VaR арга нь:

1. Итгэлцлийн түвшинг 99 хувиар авч үздэг.
2. Сүүлийн ажлын 250 хоногийн өгөгдөлд тулгуурладаг.
3. Санхүүгийн хэрэгслүүдийн хоорондын үнийн хамаарлыг тооцдог.

VaR арга нь зах зээлийн ердийн нөхцөлд санхүүгийн хэрэгслүүдийн үнийн өөрчлөлтөөс үүдэн дараагийн бизнес өдөрт банкны нийт багцаас алдаж болох алдагдлын хэмжээг тодорхой итгэлцлийн түвшинд харгалзуулан хэмждэг.

Түүнчлэн тус банк өөрийн хэрэглэж буй VaR арга нь банкны зах зээлийн эрсдлийг хэрхэн үнэн зөв, бодитой хэмжиж байгааг тогтоох зорилгоор VaR аргадаа back-testing буюу буцаан тест хийдэг. Буцаан тестийн үр дүнд тус банкны хэрэглэж буй VaR арга нь банкны зах зээлийн эрсдлийг бодитойгоор хэмжиж байгаа нь нотлогдсон болно.

Хүүгийн болон төлбөрийн чадварын эрсдэл

Тайлант онд тус банкны хүүгийн эрсдлийг удирдах үйл ажиллагаа нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс үүсч бий болох цэвэр хүүгийн орлого дахь нөлөөллийг багасгах, хүүгийн өөрчлөлтөөс банкны үр дүнд эерэг нөлөө үзүүлж байхаар тэнцлийн бүтцийг бий болгох, түүнийг хянахад чиглэгдэж ажиллаа. Өөрөөр хэлбэл:

1. Хүүгийн өөрчлөлтөөс үүдэн цэвэр хүүгийн орлого буурахаас сэргийлэн багцыг удирдах
2. Хүүгийн өөрчлөлтөөс үүдэн багцын зах зээлийн үнэ цэнэ буурахаас сэргийлж багцыг удирдах зэрэгт үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд хүүгийн эрсдлийг хэмжих GAP, DGAP (duration GAP) тайлангуудыг сар бүр тогтмол гаргаж, үр дүнг хянан, улмаар үүнд үндэслэн хүүгийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүллээ. 2004 оны эцсийн байдлаар тус банкны нийт хүүнд мэдрэмжтэй актив 159 тэрбум, хүүнд мэдрэмжтэй пассив 118 тэрбум төгрөгт хүрч, зөрүү нь 40.6 тэрбум төгрөг болсон байна.

Мэдээллийн технологийн үйл ажиллагаа

ХХБ 2004 онд мэдээллийн технологийн системээ илүү боловсронгуй болгох ажлыг өргөн далайцтайгаар өрнүүлээ.

Мэдээллийн Технологийн Хэлтсийн ажилтнууд болон сервер компьютерийн өрөөг шинэчлэн зохион байгуулж, серверийн өрөөг ерөнхий хамгаалагдсан хэсэг, түүний дотор талд соронзон картаар бүртгэх цоож бүхий серверийг зориулалтаар нь ангилсан тусдаа өрөөнүүдийн зохион байгуулалтанд оруулж, техник тоног төхөөрөмжийн хэсэгт стандарт нөхцлийг бүрдүүлэх хөргөлтийн систем, цахилгаан тэжээлийн эх үүсвэр, бусад тоноглолыг хийсэн нь харилцагчийн мэдээллийг хадгалах болон үйлчилгээний тасралтгүй ажиллагааг хангахад чухал хүчин зүйл болсон юм.


Мэдээллийн найдвартай хадгалалтыг хангах чиглэлээр төв байрнаас алслагдсан зайд нөөц хуулбар авах системийг нэвтрүүлснээр тус банкны серверт байрлаж байгаа бүх мэдээлэл онлайн горимд хуулбарлагдаж, харилцагчийн мэдээллийг ямар ч тохиолдолд найдвартай хадгалах нөхцлийг бүрдүүлж чадсан Монгол улсын анхны банк боллоо.

Австрали улсын FNS компанийн бүтээгдэхүүн банкны үндсэн бүртгэл тооцоог хөтлөх BANCS программыг шинэчлэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, олон улсын стандартад нийцүүлэв.


Нийт 17 салбар нэгжийг төв банктай онлайн холболттой болгосноор төвлөрсөн мэдээллийн сантай болж, банкны хөрөнгө зохицуулалт, тайлан тэнцэл авах ажил хөнгөвчлөгдөн, удирдах шатанд шуурхай үнэн зөв мэдээллээр хангагдаж, харилцагчийн гүйлгээ орон зайн хамааралгүйгээр шууд хийгдэх болсон нь энэ онд гарсан том дэвшлийн нэг байв.

Интернетээр харилцах данс болон VISA картын дансны хуулга үзэх систем, SMS текстээр харилцагчийн дансны үлдэгдэл илгээх системийг зохион нэвтрүүлж банкны бүтээгдэхүүн болгосон.

Олон улсын төлбөр тооцооны SWIFT системийг өргөтгөн SWIFT NET системд амжилттай оруулж, SWIFT системийн мэдээллийг банкны үндсэн бүртгэл тооцоог хөтлөх BANCs программтай холбох программ хангамжийг боловсруулж нэвтрүүлснээр тус банкны бүх салбар нэгжийн хэмжээнд гадаад төлбөр тооцоог урьд өмнөхөөс улам шуурхай гүйцэтгэх боломжийг нээж өглөө.



УЛААНБААТАР ХОТЫН САЛБАР ТООЦООНЫ ТӨВҮҮД



Хүний нөөц, боловсон хүчний бодлого

Хүний нөөцийн газар нь тус банкныг өндөр мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвартай боловсон хүчнээр хангах, тэднийг хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг удирдах, үнэлэх, урамшуулах болон хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л харилцааг зохицуулах үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Банкны одоогийн болон ирээдүйн амжилт ололт нь банкны ажилтнуудын идэвхи зүтгэл, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараас үлэмж хамааралтай болохыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тэднийг ажилдаа сэтгэл ханамжтай байх, ур чадвараа байнга сайжруулах, хүч чадлаа дээд зэргээр дайчлан ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж, сурч боловсрох, мэргэжилдээ ахиж дэвших аливаа санаачилгыг нь хөхүүлж дэмжин ажиллалаа.

Банкны ажил үйлчилгээний нэр төрөл, цар хүрээ өргөжихийн хирээр 2004 онд албан тушаал тус бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн боловсон хүчнийг сонгон авах, албан тушаал дэвшүүлэх буюу сэлгүүлэн ажиллуулах зэргээр боловсон хүчний нөхөн хангалтаар нийт 51 ажилтныг шинээр авч, 38 ажилтан ажлаас чөлөөлөгдсөнөөр банкны нийт ажилтнуудын тоо 426 боллоо. Нийт ажилтнуудын 75.6 хувь нь дээд боловсролтой байна.

Ажилтны ур чадвар, ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбосон цалинурамшууллын системийг боловсруулан хэрэгжүүлээд байна.


Хүний нөөцийн газраас 2004 онд ХХБ-наас ажилтнуудаа сургах, хөгжүүлэх талаар баримтлах бодлого, сургалтын ажлын төлөвлөгөөг боловсруулсны хүрээнд дотоодын сургалтын байгууллагууд болон банкны удирдах ажилтнуудын зохион байгуулсан сургалтуудад нийт 276, гадаад орнуудад зохион

байгуулагдсан сургалтуудад 19 ажилтныг хамруулан оролцуулав. Сургалтын агуулга ач холбогдлыг банкны стратегитай уялдуулан сонгосон бөгөөд 2004 оны сургалтын төсвийн гүйцэтгэл 118.1 сая төгрөг байна.

Банкны боловсон хүчний мэдээллийн шинэ программ хангамжийг нэвтрүүлж, төв банк, хотын салбар, тооцооны төвүүдийн ажилтнуудын холбогдох мэдээллийг шинэчилж орууллаа.

Тус банк 2004 онд ажиллагсаддаа зориулан нийт 32.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж олгожээ.

Улмаар ХХБ 2004 онд 33 орны 65 санхүүгийн байгууллагыг эгнээнд ээнгэгтгэсэн, бүснугийн хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгуулага болох Ази Номхон Далайн Орнуудын Санхүүгийн Хөгжлийн Байгууллагаас зарласан гишүүн байгууллагуудын өнгөрсөн онд хэрэгжүүлсэн шилдэг хөгжлийн төслийн шалгаруулалтанд оролцож, “Хүний нөөцийн шилдэг төсөл” номинацид шалгарсан байна.



ХХБ нь олон нийтийн сайн сайхны төлөөх ажил үйлсийг нэн идэвхтэй дэмждэг бөгөөд 2004 оны туршид бид нийгмийн, шашны, байгаль орчны болон эрүүл мэндийн холбогдолтой үйл ажиллагаануудыг санхүүжүүлж, дэмжихэд үлэмж хэмжээний хөрөнгө зарцууллаа.



Аудиторын Тайлан

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛГОСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	30
АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	31
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	32
ТАЙЛАН ТЭНЦЭЛ	33
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	34
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	35 - 36
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	37 - 69

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

БҮРТГЭГДСЭН ХАЯГ БА
БАЙРШИЛ

: Худалдааны гудамж - 7
Улаанбаатар - 11
Монгол Улс

ТУЗ-ийн ГИШҮҮД

: Фабио Калиа
Жан Бодуа
Роберто Бонзи
Рик Смит
Дашзэвэг Зоригт

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА :

Д.Даваажав

АУДИТОРУУД

: Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ (цаашид “Банк” гэх) захирлуудын хоёр нь болох ФАБИО КАЛИА, ЖАН БОДУА түүнчлэн Банкны санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан ДЕННИС ОПЕНШО, бид энэхүү тайлангийн 3 - 41 дугаар хуудсанд үзүүлсэн Банкны санхүүгийн тайлангууд нь 2004 оны 12 сарын 31-ний байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн мөнгөн гүйлгээ, үр дүнг үнэн зөв, бодитой илэрхийлэх үүднээс холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол Банкаас баталсан дүрэм журмын дагуу бэлтгэгдсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



ФАБИО КАЛИА



ЖАН БОДУА

ДЕННИС ОПЕНШОО

Улаанбаатар хот

АУДИТЫН ДҮГНЭЛТ

МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

 **ERNST & YOUNG** Mongolia Audit Company

■ МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ
БӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛД
Улаанбаатар
Монгол Уул

■ Утас: 976- 43 6269
Факс: 976- 43 6249
www.ey.com

Монгол Улсын Худалдаа Хөгжлийн Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлд

Бид 3 - 41 дүгээр хуудсанд үзүүлсэн Худалдаа Хөгжлийн Банкны 2004 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Эдгээр санхүүгийн тайланг бэлтгэж гаргах нь Банкны ТУЗ-ийн үүрэг байна. Хийж гүйцэтгэсэн аудитынхаа үр дүнд тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм.

Бид аудитаа холбогдох Аудитын Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй байгаа эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлан дахь дүн, мэдээллүүдийн дагалдах нотолгоог түүврийн аргаар шалгах ажиллагаа багтдаг. Мөн аудитын явцад захирлуудын хийсэн томоохон тооцооллууд ба ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангийн толилуулгад үнэлэлт өгөх ажлууд орно. Бидний гүйцэтгэсэн аудит нь дүгнэлт гаргахад хангалттай үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь 2004 оны 12 сарын 31-ний байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлэх үүднээс холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол Банкаас баталсан дүрэм журмын дагуу бэлтгэгдсэн байна.



Ernst & Young Mongolia Audit Co.

31 MAR 2005

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГО,
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тодруулга	2004 мян. төг	2003 мян. төг
Хүүгийн орлого	4	16,163,121	12,025,680
Хүүгийн зардал	5	(4,261,748)	(3,366,456)
Хүүгийн цэвэр орлого		11,901,373	8,659,224
Хүүгийн бус орлого	6	6,331,178	5,008,694
Үйл ажиллагааны ашиг		18,232,551	13,667,918
Үйл ажиллагааны зардал	7	(8,917,872)	(5,589,954)
Эрсдлийн сангийн өмнөх ашиг		9,314,679	8,077,964
Болзошгүй эрсдлийн сангууд	8	(1,924,549)	(3,919,446)
Татварын өмнөх ашиг		7,390,130	4,158,518
Татвар	9	(2,033,343)	(1,584,512)
Тайлант жилийн цэвэр ашиг		5,356,787	2,574,006

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК
2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

	Тодруулга	2004 мян. төг	2003 мян. төг
АКТИВ			
Бэлэн мөнгө богино хугацаат хөрөнгө	10	12,190,256	10,726,723
Банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж	11	48,786,539	74,222,557
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	12	23,929,116	53,686,304
Зээл ба урьдчилгаа	13	88,804,485	55,468,039
Бусад актив	14	2,312,360	396,849
Засгийн газрын урт хугацаат бонд	15	-	-
Үндсэн хөрөнгө	16	8,250,476	8,139,018
НИЙТ АКТИВ		184,273,232	202,639,490
ПАССИВ			
Харилцагчдын хадгаламж	17	135,373,721	178,585,101
Банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж	18	3,319,414	1,754,797
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл	19	11,052,549	8,257,671
Хоёрдогч өглөг	20	9,695,624	-
Бусад пассив	21	1,919,356	404,752
Татварын өглөг		182,040	163,840
НИЙТ ПАССИВ		161,542,704	189,166,161
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Дүрмийн сан	22	5,150,691	2,000,000
Нэмж төлөгдсөн капитал		2,749,721	-
Дахин үнэлгээний сан		3,152,619	3,152,619
Хуримтлагдсан ашиг		11,677,497	8,320,710
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		22,730,528	13,473,329
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		184,273,232	202,639,490
БОЛЗОШГУЙ ҮҮРЭГ, ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ЗҮЙЛС	26	25,794,184	25,740,706

The accompanying notes form an integral part of the financial statements.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Дүрмийн сан мян. төг	Үл хуваарилагдах		Хуваарилагдах	
		Нэмж төлөгдсөн капитал мян. төг	Дахин үнэлгээний сан* мян. төг	Хуримтлагдсан ашиг мян. төг	Дүн мян. төг
2003 оны 1-р сарын 1-нээрх	2,000,000		3,152,619	5,746,704	10,899,323
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	2,574,006	2,574,006
2003 оны 12-р сарын 31-нээрх	2,000,000	-	3,152,619	8,320,710	13,473,329
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	5,356,787	5,356,787
Хуримтлагдсан ашгийн капиталжуулалт	1,150,691	2,749,721	-	-	3,900,412
Нөөц хоорондын шилжүүлэг	2,000,000	-	-	(2,000,000)	-
2004 оны 12-р сарын 31-ний байдлаар	5,150,691	2,749,721	3,152,619	11,677,497	22,730,528

*Дахин үнэлгээний сан нь 1999 онд Банкны үндсэн хөрөнгөд хараат бус хөрөнгийн үнэлгээний компанийн хийсэн дахин үнэлгээнээс үүссэн.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2004 мян. төг	2003 мян. төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	7,390,130	4,158,518
<i>Тохируулга:-</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	814,391	711,198
Данснаас хассан үндсэн хөрөнгө	7,306	44,563
Зээлийн болзошгүй эрсдлийн сан	(388,230)	3,905,741
Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын эрсдлийн сан	27,964	10,241
Аккредитив болон баталгааны эрсдлийн сан	5,895	3,464
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдлийн сан	2,246,090	-
Авлагын эрсдлийн сан	32,830	-
Болзошгүй эрсдлийн сангийн буцаалт	-	(70,822)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз (олз)	53,170	(2)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үеийн үйл ажиллагааны ашиг	10,189,546	8,762,901
<i>Үйл ажиллагааны активын (өсөлт)/бууралт:-</i>		
Зээл ба урьдчилгаа	(32,777,776)	(13,047,637)
Бусад актив	(4,191,318)	90,877
<i>Үйл ажиллагааны пассивын өсөлт/ (бууралт):</i>		
Харилцагчдын харилцах, хадгаламж	(43,349,266)	69,581,776
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах хадгаламж	1,564,617	(1,717,340)
Бусад пассив	1,445,601	(183,576)
Үйл ажиллагаанаас орсон бэлэн мөнгө	(67,118,596)	63,487,001
Орлогын албан татварын төлөлт	(2,015,904)	(250,000)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(69,134,500)	63,237,001
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын цэвэр (өсөлт)/бууралт	29,729,224	(31,639,275)
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(880,011)	(817,052)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	168,276	69
Худалдан авсан банк бус санхүүгийн байгууллага	А	(205,208)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	28,812,281	(32,456,258)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн цэвэр өсөлт	2,753,698	2,671,982
Хоёрдогч өглөгөөс орсон мөнгөн орлого	9,695,624	-
Дүрмийн сангийн өсөлт	3,900,412	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	16,349,734	2,671,982
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)	(23,972,485)	33,452,725
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,949,280	51,496,555
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	В	60,976,795

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ) 2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ БАЙДЛААРХ

A Худалдан авсан банк бус санхүүгийн байгууллагын хөрөнгө , өр төлбөрийн бодит үнэ цэнэ дараахь байдалтай байна:

	4.6.2004 мян. төг	
Худалдан авсан цэвэр хөрөнгө:		
Цэвэр үндсэн хөрөнгө (Тодруулга)	15,705	
Зээл ба урьдчилгаа	176,335	
Банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж	81,695	
Бусад хөрөнгө	3,114	
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	113,097	
Харилцагчдын хадгаламж	(137,886)	
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл	(41,180)	
Бусад пассив	(69,003)	
Татварын өглөг	(761)	
Нийт цэвэр активын өнөөгийн үнэ цэнэ	141,116	
Худалдан авалтаас үүссэн гүүдвилл	258,884	
Мөнгөөр төлөгдсөн дүн	400,000	
Худалдан авалтаас үүссэн цэвэр гарах мөнгөн урсгал:		
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	400,000	
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	(194,792)	
	205,208	
B. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараахь зүйлс багтсан болно:		
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	12,190,256	10,726,723
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	48,786,539	74,222,557
	60,976,795	84,949,280

The accompanying notes form an integral part of the financial statements.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН)

1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус Банк нь Монголбанкнаас олгосон 13 тоот лицензийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Тайлант хугацаанд банкны үйл ажиллагааны чиглэлд онцын өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол улсад бүртгэгдэж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд нээлттэй хийгээд хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

Швейцарын Banca Commercial Lugano болон Стамфордын Gerald Metals, Inc. компанийн хамтарсан компани болох Люксембург улсад хуулийн этгээдээр албан ёсоор бүртгэлтэй Globull Investment and Development (SCA) компани нь тус Банкны толгой компани болно.

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн шийдвэрийн дагуу 2004 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Банкны санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Монголбанкнаас баталсан дүрэм, журмын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг тооцохоос бусад тохиолдолд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг тусгах үүднээс тохируулсан түүхэн өртгийн зарчмыг баримталсан болно. Санхүүгийн тайланд ашигласан мөнгөний нэгж нь Монгол төгрөг бөгөөд мянганы орноор илэрхийлсэн.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нь санхүүгийн тайлангийн өдрөөрх тайлан тэнцэлд толилуулсан актив, пассивын хэмжээ, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга, мөн тайлант хугацааны турш дахь орлого, зардлын хэмжээг урьдчилсан төсөөлөл, тооцоолол ашиглан хийхийг шаарддаг ба үүний дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн. Хэдийгээр эдгээр тооцоо, дүгнэлт нь тухайн үйл явдал, арга хэмжээний талаарх Банкны удирдлагын олж мэдсэн бодитой мэдээлэл дээр тулгуурладаг хэдий ч бодит үр дүн нь эдгээр тооцоо, дүгнэлтээс эцсийн дүндээ зөрүүтэй байж болно.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

(а) Хүүгийн орлого, зардал

Хүү тооцдог бүх л хэрэгслийн хувьд хүүгийн орлого ба зардлыг худалдан авалтын бодит үнэд үндэслэн, үр ашигт хүүгийн аргыг ашиглан, аккрузель сууриар орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Хүүгийн орлогод тогтмол хүүтэй хөрөнгө оруулалт болон арилжааны үнэт цаасны орлого, хуримтлагдсан дискаунт болон Монголбанкны үнэт цаас ба бусад дискаунтчилсан санхүүгийн хэрэгслүүдээс олсон орлого багтана.

Монголбанкны журмын дагуу зээлийн төлбөр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрвэл хүү тооцохыг зогсоодог. Ийнхүү хүү хуримтлуулахыг зогсоосон тохиолдолд хуримтлагдсан хүүг буцааж, данснаас хасдаг. Хүү тооцолтыг зогсоосноос хойш төлөгдсөн хүүг мөнгөн сууриар бүртгэдэг. Хүү төлөгдөхгүй байх эргэлзээ арилсан үед хүүгийн төлбөрийг аккрузль сууриар хүлээн зөвшөөрч эхлэх ба уг зээлийг хэвийн зээлд дахин ангилна.

(б) Шимтгэл, хураамжийн орлого

Шимтгэл, хураамжийн орлогыг үйлчилгээ үзүүлсний дараа аккрузль сууриар хүлээн зөвшөөрдөг. Тус банкны шимтгэл, хураамжийн орлогыг гол төлөв мөнгөн гуйвуулгын үйлчилгээний шимтгэл, дебит болон кредит картны үйлчилгээний хураамж, харилцах данснаас бэлэн мөнгө гаргасны шимтгэл, зээлийн материал боловсруулсны хураамж, аккредитив нээх болон банкны баталгаа гаргахад авах шимтгэл зэрэг бүрдүүлдэг.

(в) Гадаад валют

Гадаад валютаар хийсэн гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн зүйлсийг балансын дуусгавар болсон өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэнэ. Харин гадаад валютын форвард гэрээ байгуулсан тохиолдолд тухайн форвард гэрээнд тусгасан валютын ханшийг баримталдаг. Анхнаасаа гадаад валютаар илэрхийлэгдэж, түүхэн өртгөөр бүртгэгдсэн мөнгөн бус зүйлсийг худалдан авсан өдрийн түүхэн ханшаар, харин бодит өртгөөр бүртгэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн өртөг тодорхойлогдсон үеийн валютын ханшийг ашиглан төгрөгт хөрвүүлэн бүртгэнэ.

Гадаад валютын ханшийн зөрүүг бүгдийг нь орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Хэрэглэгдсэн гол гадаад валютуудын тайлан тэнцлийн өдрийн албан ханшийг үзүүлбэл:

	2004	2003
Америк доллар	1,209.00	1,168.00
Английн Фунт	2,320.90	2,073.40
Евро	1,647.40	1,460.20
Японы иен	11.65	10.92
Швейцар франк	1,067.70	935.70
Хятадын юань	146.10	141.10

(г) Зээл ба урьдчилгаа, Зээлийн болзошгүй эрсдлийн сан

Банк нь өөрийн өмчлөлийн мөнгөн хөрөнгийг зээлдэгчид тодорхой хугацаагаар шилжүүлэхийг зээл ба урьдчилгаа гэнэ. Зээл баталгаажуулахтай холбоотойгоор гарсан хуулийн үйлчилгээний хураамж зэрэг гуравдагч талуудын зардлыг ажил гүйлгээний зардлын нэг хэсэг гэж үзнэ.

Зээлдэгчид зээлийг бэлнээр олгосон үед нь зээл ба урьдчилгааг хүлээн зөвшөөрнө.

Анх байгуулсан гэрээний нөхцлийн дагуу банк олгосон зээлээ бүрэн хэмжээгээр нь төлүүлэн авч чадахгүй гэсэн бодит нотолгоо байгаа тохиолдолд зээлийн үнэлгээний бууралтын эсрэг эрсдлийн сан байгуулна. Уг сангийн хэмжээ нь дансны үнийн болон нөхөгдөх хэмжээ хоёрын зөрүү байна, ингэхдээ нөхөгдөх хэмжээ нь зээлийн үр ашигт хүүгээр дискаунтчилсан баталгаа, зээлийн барьцаа хөрөнгийн нөхөгдөх хэмжээг оролцуулан хүлээгдэж байгаа мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдэнэ.

Тайлан тэнцлийн өдрийн зээлийн багцын бүрэлдэхүүнд болзошгүй алдагдал агуулагдсан гэсэн бодит нотолгоо байгаа тохиолдолд зээлийн эрсдлийн сангаас алдагдлыг нөхнө. Үүнийг тооцоолохдоо зээлийн багцын бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн алдагдлын өмнөх чиг хандлага, зээлдэгчид олгосон зээлийн рейтинг, мөн зээлдэгчийн бизнесээ эрхэлж буй эдийн засгийн орчны өнөөгийн нөхцөл байдал дээр үндэслэсэн. Зээл төлөгдөхгүй болсон нөхцөлд холбогдох сангаас хааж данснаас хасах ба үүний дараах зээлдэгчийн төлбөрүүд нь орлого, үр дүнгийн тайланд зээлийн болзошгүй эрсдлийн санд кредит бичилт хийнэ.

Зээл төлөгдсөний дараа үнэлгээний хэмжээ буурч байгаа тохиолдолд эрсдлийн санг зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн бууралт хэлбэрээр кредит бичилт хийж буцаана.

Зээлийн багцын хугацааны талаарх мэдээллийг 13-р Тодруулгад толилуулсанчлан тайлан тэнцлийн өдрөөс гэрээнд заасан хугацаа хүртэлх үлдсэн хугацааг харуулсан болно. Олон улсын санхүүгийн байгууллагуудын хөтөлбөрийн хүрээнд засгийн газрын санхүүжилтийн зохицуулалтыг эс тооцвол Монгол Улсад урт хугацаатай зээл бараг байдаггүй. Гэсэн хэдий ч Монголын зах зээл дээр зээлийн эргэн төлөгдөх хугацаа болоход зээлийн гэрээг сунгана гэсэн хүлээлттэйгээр богино хугацаатай зээл олгодог.

(д) Татвар

Санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон ашгийг Монгол улсын татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдохгүй орлого буюу татвараас хасагдахгүй зардлын зүйлсээр залруулан орлогын албан татвараа тодорхойлдог ба тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг ашиглан тооцдог.

Тайлан тэнцлийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн дүнгийн хооронд гарах түр зөрүүнд өр төлбөрийн аргыг ашиглан хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрнө. Үндсэндээ татвар ногдох бүх түр зөрүүнд хойшлогдсон татварын өрийг татвараас хасагдах бүх түр зөрүү, ашиглагдаагүй татварын хөнгөлөлт ба чөлөөлөлтөнд дараа тооцох татварын авлагыг тэдгээрт харгалзах татвар ногдох ашиг орж ирэх нь тодорхой болсон үед хүлээн зөвшөөрнө. Хэрэв түр зөрүү нь гүүдвил, сөрөг гүүдвил, эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс бий болсон ба нягтлан бодох бүртгэлийн ашиг, татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй бол хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөхгүй.

(е) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон бусад банк, санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж, богино хугацаат сангуудаас бүрдэнэ.

(ж) Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Бүх хөрөнгө оруулалтыг эхэндээ өртгөөр нь (ажил гүйлгээний зардлыг оролцуулан) хүлээн зөвшөөрдөг. Тухайн үнэт цаасыг худалдан авсан үед уг хөрөнгө оруулалтыг хэрхэн ангилах тухай шийдвэрийг Банкны удирдлага гаргадаг.

Банкны удирдлага орлого олох эсвэл хөрөнгөө өсгөх зорилгоор дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших бодолтой болон боломжтой байгаа тохиолдолд тогтоосон хугацаатай үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилна. Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хасч бүртгэлд тусгана. Төлбөр түргэн гүйцэтгэх үүднээс, эсвэл хүү, валютын ханш эсвэл хөрөнгийн үнийн өөрчлөлтийн улмаас худалдах боломжтой ба тодорхой бус хугацаагаар эзэмшиж буй үнэт цаасыг борлуулахад бэлэн байгаа үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэж ангилдаг.

Борлуулахад бэлэн байгаа санхүүгийн хөрөнгийг зах зээл дээрх үнийн санал эсвэл мөнгөн урсгалын (өнөөгийн үнэ цэнийн) тооцоолол зэрэгт үндэслэн бодит үнээр тухайн үед нь дахин илэрхийлнэ. Хөрөнгийн бирж дээр арилждаагүй үнэт цаасны бодит үнэ цэнийг тухайн үнэт цаас гаргасан этгээдийн нөхцөл байдлыг тусгах зорилгоор холбогдох үнэ ба ашиг эсвэл үнэ ба мөнгөн урсгалын харьцаа үзүүлэлтүүдийг ашиглан тооцоолно. Борлуулахад бэлэн гэж ангилсан үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит бус олз, гарзыг өөрийн хөрөнгөд бүртгэдэг. Бодит үнэ цэнийг тогтоох боломжгүй өмчийн үнэт цаасыг үнэ цэнийн бууралтыг хассан өртгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Үнэт цаасыг борлуулсан эсвэл түүний үнэ цэнэ буурсан гэж үзсэн тохиолдолд холбогдох хуримтлагдсан бодит үнэ цэнийн тохируулгыг орлого үр дүнгийн тайланд үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын олз ба гарз гэж тусгана.

Санхүүгийн хөрөнгийн дүн түүний тооцоолсон төлөгдөх хэмжээнээс давсан нөхцөлд түүний үнэ цэнэ буурдаг. Хорогдуулсан өртөг бүхий дансны үнэтэй хөрөнгийн үнэ цэнэ буурсанаас гарах гарзын хэмжээг тухайн хөрөнгийн үлдэгдэл дүн ба ирээдүйд хүлээгдэж байгаа мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хэрэгслийн өөрийнх нь хүүгийн хэмжээгээр дискаунтчилан хасч тооцно. Өөрөөр хэлбэл, бодит үнэ цэнээр хэмжигдсэн хэрэгслийн нөхөгдөх хэмжээ нь ижил төстэй хэрэгслийн зах зээлийн өнөөгийн хүүгээр дискаунтчилсан ирээдүйд хүлээгдэж байгаа мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байдаг.

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын орлогыг хүүгийн орлого гэж бүртгэдэг байна. Тухайн ногдол ашгийг зарласан үед нь ногдол ашгийн орлогод бүртгэж бичдэг.

(з) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг үнийн бууралтын гарз болон хуримтлагдсан элэгдлийг хасаад өртгөөр нь тусгасан. Тодруулга З(м)-н дагуу үнийн бууралтыг хүлээн зөвшөөрч хэмждэг.

Хараат бус хөрөнгийн үнэлгээний компанийн нээлттэй зах зээлийн үнийн аргаар хийсэн үнэлгээг үндэслэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг дор хаяж 5 жилд нэг удаа хийдэг. Дахин үнэлгээний аливаа нэмэгдлийг өөрийн хөрөнгөд дахин үнэлгээний санд бүртгэдэг. Гэхдээ өмнө нь тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг зардлаар хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө нь хүлээн зөвшөөрсөн бууралтыг тусгах үүднээс дахин үнэлгээний нэмэгдлийг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээний бууралтыг эхлээд хэрэгжээгүй дахин үнэлгээний нэмэгдлээс суутган дараа нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Банкны үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа дараахь байдалтай байна:

Барилга байшин	40 жил
Тавилга, тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер	5 жил

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулдаггүй. Эдгээр хөрөнгийн элэгдлийг ашиглалтад орох үеэс нь эхлэн тооцно.

Үндсэн хөрөнгийг борлуулахад борлуулалтын цэвэр орлого ба дансны цэвэр үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд тусгах бөгөөд тухайн үндсэн хөрөнгийн хэрэгжээгүй дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд хаана.

(н) Худалдах, буцаан худалдан авах хэлцлүүд

Буцаан худалдан авах гэрээтэйгээр (репо) худалдсан үнэт цаасуудыг санхүүгийн тайланд арилжааны эсвэл хөрөнгө оруулалтын үнэт цаас гэж тусгах ба холбогдох өр төлбөрийг бусад санхүүгийн байгууллагуудад төлөх өр төлбөрийн дүнд багтаан эсвэл аль тохиромжтой байдлаар бүртгэнэ. Дахин худалдах гэрээтэйгээр худалдан авсан үнэт цаасуудыг бусад санхүүгийн байгууллагуудаас авах авлагын дүнд багтаан эсвэл аль тохиромжтой байдлаар бүртгэнэ. Борлуулалт ба худалдан авалтын үнүүдийн хоорондох зөрүүг хүү гэж тооцох ба хүүг репо гэрээний хугацаанд үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хуримтлуулна.

(к) Харилцагчдын харилцах, хадгаламж

Харилцагчдын харилцах, хадгаламжийг ирээдүйд хүлээн авсан хадгаламжид төлөх төлбөрийн бодит үнэ болох өртгөөр нь тусгадаг.

(л) Ажиллагчдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог, бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог байна. Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлогын тайлан дахь зардалд тусгана.

(м) Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Эд хөрөнгөд өртгийн бууралтын гарз учирсан гэсэн үзүүлэлт байгаа эсэхийг тодорхойлох үүднээс Банк хөрөнгийнхөө бүртгэлийн үнийг хянаж үздэг. Хэрэв иймэрхүү үзүүлэлт оршин буй бол хөрөнгийн дансны үнийг нөхөн төлөгдөх дүнтэй харьцуулан өртгийн бууралтыг хэмждэг. Нөхөн төлөгдөх дүн нь ашиглалтын өртөг болон борлуулалтын цэвэр өртгийн аль өндөр нь байх ба энэ нь бууруулсан ирээдүйн мөнгөн гүйлгээгээр хэмжигддэг.

Хөрөнгийг дахин үнэлгээний дүнгээр тусгагдаагүй л бол өртгийн бууралтын гарзыг гарсан даруйд нь орлогын тайланд тусгана. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн үнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн өмнө нь бүртгэгдсэн дахин үнэлгээний нэмэгдлээс хасч дахин үнэлгээний бууралтаар бүртгэнэ. Тухайн хөрөнгийн үнийн бууралт цаашид гарахгүй буюу буурах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнийн бууралтын буцаалтыг бүртгэдэг.

(н) Санхүүгийн хэрэгслүүд

Банк санхүүгийн хэрэгслийн гэрээний заалтуудад холбогдогч тал болсон үед санхүүгийн хэрэгслүүдийг тайлан тэнцэлд тусгана. Эдгээр хэрэгслүүдийг хүлээн зөвшөөрөх болон хэмжихтэй холбогдсон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг тэдгээрийн холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгасан болно.

Гэрээний агуулгын дагуу санхүүгийн хэрэгслүүдийг өр төлбөр эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Өр төлбөр гэж ангилагдсан Санхүүгийн хэрэгслийн холбогдох хүү, ногдол ашиг, ашиг ба алдагдлыг зардал эсвэл орлого гэж бүртгэнэ. Банк нь санхүүгийн хэрэгслүүдийг хууль зүйн хүрээнд, актив пассивыг хооронд нь цэвэршүүлэн хаах буюу актив, пассивын төлбөр тооцоог нэгэн зэрэг гүйцэтгэх замаар хаадаг.

(i) Өмчийн хэрэгслүүд

Дүрмийн санг өөрийн хөрөнгөд ангилах бөгөөд ногдол ашгийг тухайн зарласан үед нь өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

(ii) Үүсмэл санхүүгийн хэрэгслүүд

Гадаад валютын арилжааны хэлцэл, хүүгийн хувь хэмжээний фьючерс, форвардын хувь хэмжээний хэлцэл, валютын ханш болон хүүгийн хувь хэмжээний своп, валютын ханш болон хүүгийн хувь хэмжээний опцион (худалдсан ба худалдан авсан) болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг тайлан тэнцэлд анх бүртгэхдээ гүйлгээний зардлыг оруулсан өртгөөр нь, түүнээс хойш бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгэнэ. Бодит үнэ цэнийг үнэт цаасны биржийн зах зээлийн үнийн жагсаалт, бууруулсан мөнгөн урсгалын загвар, опционы үнэлгээний загварын аль тохирохоос нь авна. Бүх үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ.

Хөрвөх өрийн бичгийн хөрвөх опцион гэх мэт бусад санхүүгийн хэрэгслүүдийн салшгүй нэг хэсэг нь болж байдаг тодорхой нэг үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг тэдгээрийн эрсдэл ба шинж чанар нь үндсэн хэлцлийнхээ эрсдэл, шинж чанартай шууд холбоогүй байгаа ба үндсэн хэлцлийг орлогын тайланд тусгасан бодит бус олз, гарзыг тооцсон бодит үнэ цэнээр нь бүртгээгүй үед тусдаа бие даасан санхүүгийн үүсмэл хэрэгсэл гэж бүртгэнэ.

Арилжааны зориулалттай санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг арилжааны цэвэр орлогод тооцно.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийг байгуулсан өдрөөс Банк нь тухайн санхүүгийн үүсмэл хэрэгслийг 1) хүлээн зөвшөөрсөн буюу тайлан тэнцэлд тусгасан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн эрсдлийн саармагжуулагч (бодит үнэ цэнийн эрсдлийн саармагжуулагч) эсвэл 2) хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрт харгалзах ирээдүйн мөнгөн урсгалын эрсдлийн саармагжуулагч (мөнгөн урсгалын эрсдлийн саармагжуулагч) гэж ангилна. Тодорхой шалгуур үзүүлэлтүүд хангагдсан тохиолдолд эдгээр санхүүгийн хэрэгслүүдэд эрсдэл саармагжуулалтын бүртгэлийг хэрэглэнэ.

Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг эрсдэл саармагжуулагч гэж бүртгэхдээ Банкны харгалзан үзэх шалгуур үзүүлэлтүүдэд:

а) Эрсдэл саармагжуулагч хэрэгсэл, эрсдэл нь саармагжих зүйл, эрсдэл саармагжуулалтын зорилт, стратеги, уялдаа холбооны талаарх албан ёсны бичиг баримтуудыг эрсдэл саармагжуулах бүртгэлийг хэрэглэхээс өмнө бэлтгэсэн байх;

б) Эрсдэл саармагжуулалтын холбогдох бичиг баримтууд нь тайлант хугацааны туршид тухайн зүйлийн эрсдлийг өндөр үр нөлөөтэйгээр бууруулж чадна гэдгийг харуулж байх;

в) Эрсдэл саармагжуулалт нь урт хугацаанд өндөр үр нөлөөтэй байх;

Бодит үнэ цэнийн эрсдлийг саармагжуулагч гэж ангилагдсан ба тухайн эрсдлийг бууруулах өндөр үр нөлөөтэй гэж үзсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн нөлөөлөхүйц хэсгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлогын тайланд харгалзах хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хамт тусгана.

Хэрэв эрсдэл саармагжуулалт нь эрсдэл саармагжуулалтын бүртгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж чадахгүй болсон бол эрсдэл нь саармагжиж байгаа, хүүтэй санхүүгийн үүсмэл хэрэгслийн бүртгэлийн үнэд хийсэн залруулгыг тухайн санхүүгийн хэрэгслийн дуусах өдөр хүртэлхи хугацааны туршид тэгш хуваарилан цэвэр ашиг, алдагдлын данс руу буцаана.

Мөнгөн урсгалын эрсдлийг саармагжуулагч гэж ангилагдсан ба тухайн эрсдлийг бууруулах өндөр үр нөлөөтэй гэж үзсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн нөлөөлөхүйц хэсгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг өөрийн хөрөнгийн хэсэгт эрсдэл саармагжуулалтын нөөц гэж тусгана. Урьдчилан төлөвлөсөн гүйлгээ эсвэл хатуу нөхцөлтэй хэлцлүүд нь хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд хүргэж байгаа үед өөрийн хөрөнгөд урьд нь бүртгэгдсэн олз, гарзыг өөрийн хөрөнгөөс хасаж харгалзах хөрөнгө, өр төлбөрийн анхны өртөгт шингээнэ. Үгүй бол өөрийн хөрөнгөд бүртгэсэн дүнг эрсдэл нь саармагжиж байгаа хатуу нөхцөлтэй хэлцэл эсвэл урьдчилан төлөвлөсөн гүйлгээ нь орлогын тайланд нөлөө үзүүлж байгаа тухайн хугацаанд нь орлого эсвэл зардал гэж ангилан орлогын тайланд тусгана. Банкны эрсдлийн удирлагын бодлогын хүрээнд үр ашигтай эрсдлийн саармагжуулалтыг бий болгож байгаа тодорхой нэг санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг НББОУС-39-ийн тусгай заалтуудын дагуу эрсдэл саармагжуулалтын бүртгэлээр бүртгэдэггүй ба тиймээс бодит үнэ цэнийн олз эсвэл гарз нь орлогын тайланд тусгагддаг арилжааны зориулалттай санхүүгийн үүсмэл хэрэгслүүд гэж бүртгэнэ.

4. ХҮҮГИЙН ОРЛОГО

	2004 мян. төг	2003 мян. төг
Зээл ба урьдчилгаа	13,738,295	9,560,238
Монголбанкны үнэт цаас	787,036	1,463,065
Засгийн газрын үнэт цаас	847,102	486,008
Банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	708,800	472,011
Худалдах, буцаан худалдан авах хэлцлүүд	29,914	44,358
Корпорацийн бонд	51,974	-
	16,163,121	12,025,680

5. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

	2004 мян. төг	2003 мян. төг
Хугацаатай ба хугацаагүй хадгаламжийн хүү	2,508,125	2,052,857
Харилцахын хүү	1,195,635	1,042,988
Бусад	79,788	
Банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл	402,560	199,873
Худалдах, буцаан худалдан авах хэлцлүүд	155,428	70,738
	4,261,748	3,366,456

6. ХҮҮГИЙН БУС ОРЛОГО

	2004 мян. төг	2003 мян. төг
Шимтгэл хураамжийн орлого:		
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний шимтгэл	659,791	757,570
Харилцах данснаас бэлэн мөнгө гаргасны шимтгэл	570,742	508,482
Кредит картын үйлчилгээний хураамж	556,869	515,829
Аккредитив ба баталгаа гаргасны шимтгэл	399,796	350,118
Бусад шимтгэлийн орлого	641,789	540,846
Бусад орлого:		
Гадаад валютын бодит цэвэр олз	2,199,157	899,661
Гадаад валютын бодит бус цэвэр олз/(гарз)	(63,264)	165,454
Үнэт металлын бодит цэвэр олз	631,589	209,235
Үнэт металлын бодит бус цэвэр олз/(гарз)	(62,986)	(251,335)
Түрээсийн орлого	110,415	93,415
Сангийн буцаалт	343,971	70,822
Данснаас хасагдсан зээлийн эргэн төлөлт	226,211	1,123,027
Үйл ажиллагааны бус бусад орлого	117,098	25,570
	3,502,191	2,335,849
Хүүгийн бус орлогын дүн	6,331,178	5,008,694

7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2004 мян. төг	2003 мян. төг
Цалин, бусад төлбөрүүд	2,066,255	2,206,153
Элэгдэл	814,391	711,198
Харилцаа холбоо	414,804	344,015
Мэдээллийн системтэй холбоотой зардал	347,533	301,478
Мөнгө хураалт	226,096	248,765
ING Техник туслалцааны төлбөр	2,488,350	231,800
Сургалт	237,280	170,993
Гадаадын санхүүгийн байгууллагуудад төлөх үйлчилгээний хураамж	225,966	170,548
Зар сурталчилгаа	311,485	159,264
Зочин төлөөлөгчийн зардал	178,205	129,688
Үндсэн хөрөнгийн урсгал засвар	60,329	112,455
Түрээс	272,299	106,386
Ашиглалтын зардал	94,122	87,745
Томилolt	109,218	80,129
Шатахуун, тээврийн хэрэгсэл	69,207	78,721
Цэрэгжүүлсэн хамгаалалт, аюулгүй байдал	76,753	65,279
Бичиг хэргийн зардал	113,705	59,683
Зээл болон авлага барагдуулах зардал	332,115	53,327
Гишүүнчлэл ба аудитын зардал	220,202	53,116
Хөдөлмөр хамгаалал	14,865	47,395
Данснаас хассан үндсэн хөрөнгө	7,306	44,563
Даатгал	42,111	41,336
Үл хөдлөх хөрөнгийн татвар	32,939	33,051
Хандив тусламж	39,719	15,089
Борлуулсан үндсэн хөрөнгө	53,170	-
Үйл ажиллагааны бусад зардал	69,447	37,777
	8,917,872	5,589,954

Тайлант жилд тус банкинд ажиллагчдын дундаж тоо нь дараахь байдалтай байна:

Үүнд:

	2004 Тоо	2003 Тоо
Захирлууд	24	24
Салбарын удирдлагууд	14	14
Банкны гүйцэтгэх ба үйлчилгээний ажилчид	401	374
Үүнээс:		
- банкны төвд	272	252
- салбаруудад	167	160
	439	412

8. ЭРСДЛИЙН САНГУУД

	2004 мян. төг	2003 мян. төг
Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлийн сан	(388,230)	3,905,741
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын эрсдлийн сан	27,964	10,241
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдлийн сан	2,246,090	-
Бусад хөрөнгийн эрсдлийн сан	32,830	-
Аккредитив болон баталгааны эрсдлийн сан	5,895	3,464
	1,924,549	3,919,446

9. ТАТВАР

	2004 мян. төг	2003 мян. төг
Орлогын татвар:		
Тайлант жилийн үр дүнд ногдох татвар	2,033,343	1,584,512

Монгол улсын хуулийн этгээд нь татвар ногдох орлогоо үнэн зөв тодорхойлон, зохих татварын байгууллагад төлдөг. Банк 100 сая төгрөг хүртэл ашгаас 15%-ийн, 100 саяас дээш төгрөгийн ашгаас 30% (2003 : 40%)-ийн орлогын албан татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүгийн орлогод татвар тооцохгүй. Зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах сан нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцогдоно.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд хэрхэн тохируулсныг дараахь байдлаар үзүүлэв.

Үүнд:

	2004 мян. төг	2003 мян. төг
Татварын өмнөх ашиг	7,390,130	4,158,518
Орлогын албан татварын хэмжээ 30% (2003 онд: 40%)	2,217,039	1,663,407
Татварын хувь хэмжээнээс доогуур татвар ногдуулдаг орлого	(15,000)	(25,000)
Татвараас чөлөөлөгдөх орлого	(254,131)	(194,403)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	85,435	140,508
Тайлант жилийн татварын зардал	2,033,343	1,584,512

Санхүүгийн тайланд хойшлогдсон татварыг тусгадаггүй.

Банк нь өөрийн үйл ажиллагаанд хамаарах татварын хуулиудад заасны дагуу татвараа төлж буй гэж Банкны удирдлага үздэг.

10. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2004 мян. төг	2003 мян. төг
Мөнгөн хөрөнгө:		
Төгрөгийн касс ба харилцах	3,350,750	3,454,183
Валютын касс ба харилцах	8,839,506	7,272,540
	12,190,256	10,726,723

11. БУСАД БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2004 мян. төг	2003 мян. төг
Монголбанкин дахь харилцах	5,209,340	5,949,208
Банк санхүүгийн байгууллагууд дахь хөрөнгө	43,577,199	68,273,349
	48,786,539	74,222,557

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу хөрөнгийг Монголбанкинд байршуулдаг бөгөөд дансны үлдэгдэлд хүү тооцдоггүй. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний үлдэгдлийг 15 хоногийн дундаж дээр үндэслэн тодорхой тогтоосон хувиар бодож гаргадаг.

Банк санхүүгийн байгууллага дахь хөрөнгөд гадаадын санхүүгийн байгууллагууд дахь валютын харилцах дансны үлдэгдэл багтана. Гадаад валютын харилцах дансны үлдэгдэл нь гол төлөв америк доллар (ам.дол.)-аар илэрхийлэгддэг бөгөөд жилийн 0.001%-иас 6%-ийн хүүтэй байдаг (2003 : 0.001%-иас 6%-ийн хүүтэй байв).

12. ҮНЭТ ЦААСАНД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2004 мян. төг	2003 мян. төг
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших:		
Монголбанкны үнэт цаас	1,661,914	23,428,428
Засгийн газрын бонд	16,681,125	28,943,508
Энгийн вексель	5,640,804	1,168,000
	23,983,843	53,539,936
Хорогдуулаагүй хямдруулалт	1,153	136,067
Үнэлгээний бууралтад байгуулсан сан	(55,880)	(15,663)
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших цэвэр үнэт цаас	23,929,116	53,660,340
Борлуулахад бэлэн үнэт цаас:		
Хувьцаа	-	110,827
Үнийн бууралтын алдагдлаас хамгаалах сан	-	(84,863)
Борлуулахад бэлэн цэвэр үнэт цаас	-	25,964
	23,929,116	53,686,304

